



Хэсэг бүтээн хэвлэл  
07 дугаар сарын 14  
№26 /647/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын  
хууль

889

Монгол Улсын  
асгийн газрын  
тогтоол

918

Монгол Улсын  
Дээд шүүхийн  
тогтоол

954

**Барааны тэмдэг, газар зүйн  
заалтын тухай**

**Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр  
батлах тухай**

**Эрүүгийн хуулийн 26 дугаар  
бүлгийн зарим зүйл, заалтыг  
тайлбарлах тухай**

**ГАРЧИГ****МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- |      |   |     |
|------|---|-----|
| 210. | Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай  | 889 |
| 211. | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 916 |
| 212. | Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай                                    | 916 |
| 213. | Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай  | 917 |

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 214. | Монголбанкны Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг чөлөөлөх, томилгох тухай | Дугаар 28 | 917 |
|------|---|-----------|-----|

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 215. | Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр батлах тухай | Дугаар 90 | 918 |
|------|---|-----------|-----|

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ**

- |      |   |           |     |
|------|---|-----------|-----|
| 216. | Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай | Дугаар 15 | 954 |
|------|---|-----------|-----|

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2010 оны 06 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАР ЗҮЙН  
ЗААЛТЫН ТУХАЙ**  
*/Шинэчилсэн найруулга/*

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь бараа, үйлчилгээний тэмдэг /цаашид "барааны тэмдэг" гэх/, газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах,



барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, газар зүйн заалтыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

## **2 дугаар зүйл. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомж**

2.1.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Иргэний хууль<sup>2</sup>, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

## **3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“барааны тэмдэг” гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг;

3.1.2.“хамтын тэмдэг” гэж тухайн улсынхаа хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийгэмлэг, холбооны гишүүд нэгдсэн хяналтын дор ашиглах барааны тэмдгийг;

3.1.3.“гэрчлэх тэмдэг” гэж тухайн бараа, үйлчилгээний чанар, үйлдвэрлэх арга, бусад онцлог шинж чанарыг эрх бүхий байгууллага гэрчлэн бусад этгээдэд ашиглуулах барааны тэмдгийг;

3.1.4.“газар зүйн заалт” гэж тухайн газар нутгийн байгаль, цаг уурын ноцол, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бүс, газар нутгийн газар зүйн тодорхойлолтыг;

3.1.5.“бүртгэгдсэн барааны тэмдэг, газар зүйн заалт” гэж хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэсэн барааны тэмдэг, газар зүйн заалтыг;

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль-Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Иргэний хууль-Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

3.1.6. "гэрчилгээ" гэж улсын бүртгэлд бүртгэгдсэн барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг гэрчилж, төрөөс олгож байгаа баримт бичгийг;

3.1.7. "барааны тэмдэг эзэмшигч" гэж бүртгэгдсэн барааны тэмдгийг өмчлөх эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан этгээдийг;

3.1.8. "газар зүйн заалт хэрэглэгч" гэж газар зүйн заалтыг өөрийн бараа, бүтээгдэхүүнд ашиглах эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан этгээдийг;

3.1.9. "мэдүүлэг" гэж барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгүүлэхийг хүссэн иргэн, хуулийн этгээдээс оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад гаргаж байгаа өргөдөл, хуульд заасан бусад баримт бичгийг;

3.1.10. "мэдүүлгийн бүрдлийн хяналт" гэж энэ хуулийн 6, 21 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах чиглэлээр оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын явуулж байгаа үйл ажиллагааг;

3.1.11. "шүүлт" гэж тухайн барааны тэмдэг, газар зүйн заалт энэ хуулийн 5, 20 дугаар зүйлд заасан шаардлага хангасан эсэхийг тогтоож, дүгнэлт гаргах оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг;

3.1.12. "лицензийн гэрээ" гэж барааны тэмдэг эзэмшигч бүртгэгдсэн барааны тэмдгийг бусад этгээдэд ашиглуулах тухай бичгээр байгуулсан хэлцлийг;

3.1.13. "нийтэд түгээмэл болсон барааны тэмдэг" гэж бүртгэгдсэн эсэхээс үл хамааран Монгол Улсын тухайн салбарт нийтэд танил болсон барааны тэмдгийг;

3.1.14. "албан ёсны тогтмол хэвлэл" гэж энэ хуульд заасан барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нийтийн хүртээл болгох зорилгоор Парисын конвенцийн 12.2-т заасны дагуу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрхлэн гаргах хэвлэл болон вэб хуудас, цахим мэдээллийг;

3.1.15. "анхдагч огноо" гэж энэ хуулийн 7.2, 11.2, 23.2-т заасан он, сар, өдрийг;



3.1.16. "давамгайлах огноо" гэж мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө Парисын конвенцийн гишүүн буюу Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн аль нэг улсад уг барааны тэмдгийг бүртгүүлэхээр мэдүүлсэн он, сар, өдөр, эсхүл Парисын конвенцийн 11 дүгээр зүйлд заасан он, сар, өдрийг;

3.1.17. "бараа, үйлчилгээний ангилал" гэж 1957 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн Ниццийн хэлэлцээрээр баталсан "Бараа, үйлчилгээний олон улсын ангилал"-ыг;

3.1.18. "барааны тэмдгийн олон улсын мэдүүлэг" гэж Мадридын хэлэлцээр, Мадридын протоколын дагуу Дэлхийн оюуны өмчийн байгууллагын оюуны өмчийн олон улсын товчоо /цаашид "Олон улсын товчоо" гэх/-оор дамжуулан гаргасан мэдүүлгийг;

3.1.19. "Парисын конвенци" гэж 1883 оны 3 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулж хянан засварласан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцийг;

3.1.20. "Мадридын хэлэлцээр" гэж 1891 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр байгуулсан, нэмэлт, өөрчлөлт оруулж хянан засварласан Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийг;

3.1.21. "Мадридын протокол" гэж 1989 оны 6 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээрийн протоколыг;

3.1.22. "Нийтлэг журам" гэж Мадридын хэлэлцээр болон Мадридын протоколыг хэрэгжүүлэх журмыг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ БАРААНЫ ТЭМДГИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ**

### **4 дүгээр зүйл. Барааны тэмдгийн илэрхийлэгдэх хэлбэр**

4.1. Барааны тэмдэг нь үг, дүрс, үсэг, тоо, гурван хэмжээст дүрс, өнгө, дуу авиа, үнэр, эсхүл тэдгээрийг хосолсон байдлаар илэрхийлэгдэж болно.

### **5 дугаар зүйл. Барааны тэмдэгт тавих шаардлага**

5.1. Ялгагдах шинж чанар агуулаагүй дараахь зүйлийг барааны тэмдэгт тооцохгүй:



5.1.1.үсэг, тоо, геометрийн энгийн дүрс, нийтээр хэрэглэдэг тэмдэглэгээ, нэр томъёо дангаараа байвал;

5.1.2.тухайн бараа, үйлчилгээг тодорхойлсон нэр, барааны тоо, хэмжээ, жин, чанар, зориулалт, үнэ, үйлдвэрлэсэн газрын нэр, арга, хугацаа зэргийг тайлбарласан үг, дүрс;

5.1.3.тухайн бараа, түүний сав, баглаа боодлын үл ялгагдах хэлбэр, дүрс;

5.1.4.Монгол Улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн нэр, дүрс дангаараа байвал;

5.1.5.Монгол Улсын түүхэн хүмүүсийн бүтэн нэр, зохиомол нэр, хөрөг, зураг, тэдгээрт шууд хамаарах төсөөллийн нэр дангаараа байвал.

## 5.2.Дараахь барааны тэмдгийг бүртгэхгүй:

5.2.1.Монгол Улсын болон Парисын конвенци, Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн улсын сүлд, далбаа, төрийн бэлгэдэл, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын бүтэн ба товчилсон нэр, албан ёсны тэмдгээс бүрдсэн, эсхүл тэдгээртэй ижил, төсөөтэй бөгөөд тухайн улс, байгууллага, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй;

5.2.2.Монгол Улсын нэрд гарсан хүний бүтэн нэр, эсхүл зохиомол нэр, хөрөг, зургаас бүрдсэн бөгөөд тухайн хүний буюу түүний өв залгамжлагчийн зөвшөөрөлгүй;

5.2.3.Монгол Улсын төрийн одон, медаль болон бусад шагнал, баталгаа, хяналтын албан ёсны тэмдэг, дэрдэстэй ижил, төсөөтэй;

5.2.4.агуулга нь нийгмийн дэг журам, зан суртахуунд харш;

5.2.5.бараа, үйлчилгээний чанар, гарал үүсэл болон бусад шинж чанарын хувьд хэрэглэгчийг төөрөгдөлд оруулж болзошгүй;

5.2.6.Монгол Улсад бүртгэгдсэн, эсхүл бүртгүүлэхээр мэдүүлсэн ижил бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдэгтэй ижил;

5.2.7.Монгол Улсад бүртгэгдсэн, эсхүл бүртгүүлэхээр мэдүүлсэн төсөөтэй бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдэгтэй ижил, төсөөтэйгээс хэрэглэгчийг төөрөгдөлд оруулж болзошгүй;



5.2.8.бараа, үйлчилгээний төрлөөс үл хамаарч нийтэд түгээмэл болсон барааны тэмдэгтэй ижил, эсхүл төсвөтэйгээс хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, шударга бус давуу эрх эдлэх, ашиг олох, хохирол учруулах, нэр хүндийг гутаахаар;

5.2.9.Монгол Улсад нийтэд түгээмэл болсон бүтээлийн зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрх, аж үйлдвэрийн өмчийн эрхтэй илэрхий зөрчилдөхөөр.

5.3.Энэ хуулийн 5.1, 5.2.1-д заасан зүйл нь тухайн барааны тэмдгийн дийлэнх хэсгийг бүрдүүлэхээргүй бол тухайн үг, дүрсийг хамгаалалтад авахгүйгээр барааны тэмдгийг бүртгэж болно.

5.4.Энэ хуулийн 5.1.5, 5.2.2-т заасан Монгол Улсын түүхэн, нэрд гарсан хүмүүсийг тодорхойлох болон барааны тэмдгийн мэдүүлэг гаргах, шүүлт хийх журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/ баталж мөрдүүлнэ.

5.5.Энэ хуулийн 3.1.13-т заасан нийтэд түгээмэл болсон барааны тэмдгийн жагсаалтыг төрийн захиргааны байгууллага баталж, энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

## **6 дугаар зүйл. Барааны тэмдгийн мэдүүлэг гаргах**

6.1.Барааны тэмдгийг бүртгүүлэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд барааны тэмдгийн мэдүүлгийг төрийн захиргааны байгууллагад монгол хэлээр гаргана.

6.2.Барааны тэмдгийн мэдүүлгийг мэдүүлэг гаргагч өөрөө, эсхүл энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргана.

6.3.Барааны тэмдгийн нэг мэдүүлэг нэг барааны тэмдэгт хамаарна.

6.4.Барааны тэмдгийн мэдүүлэг дараахь зүйлээс бүрдэнэ:

6.4.1.төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

6.4.2.энэ хуулийн 9.4-т заасны дагуу хураамж төлсөн тухай баримт болон энэ хуулийн 6.6-д заасан баримт.

6.5.Энэ хуулийн 6.4.1-д заасан өргөдөлд дараахь зүйлийг тусгана:

6.5.1.барааны тэмдгийг бүртгүүлэх тухай хүсэлт;

6.5.2.мэдүүлэг гаргагч нь иргэн бол түүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, харьяалал, байнга оршин суудаг буюу үйл ажиллагаа явуулдаг улсын нэр, мэдүүлэг гаргасан он, сар, өдөр, гарын үсэг;

6.5.3.мэдүүлэг гаргагч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэр, төрөл, хаяг, үүсгэн байгуулагдсан улсын нэр, үйл ажиллагаа явуулдаг улсын нэр, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

6.5.4.мэдүүлэг гаргагч нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж байгаа бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, гарын үсэг;

6.5.5.давамгайлах огноо хүсэх тохиолдолд энэ тухай мэдэгдэл;

6.5.6.бүртгүүлэхээр мэдүүлж байгаа барааны тэмдэг;

6.5.7.барааны тэмдгийн тодорхойлолт;

6.5.8.барааны тэмдгийн илэрхийлэгдэх хэлбэрийн тухай мэдэгдэл;

6.5.9.хамтын тэмдгээр бүртгүүлэх бол энэ тухай мэдэгдэл;

6.5.10.гэрчлэх тэмдгээр бүртгүүлэх бол энэ тухай мэдэгдэл;

6.5.11.барааны тэмдэг нь кириллээс өөр үсгээр илэрхийлэгдсэн бол тухайн тэмдгийн кирилл үсгээр галигласан хөрвүүлэг, гадаад үгээр илэрхийлэгдсэн бол түүний орчуулга;

6.5.12.тухайн барааны тэмдэгт хамаарах бараа, үйлчилгээний ангилал болон бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалт.

6.6.Барааны тэмдгийн мэдүүлэгт дараахь зүйлийг хавсаргана:

6.6.1.тухайн барааны тэмдгийг хамтын тэмдгээр бүртгүүлэх бол түүнийг ашиглах журам, түүнийг ашиглах эрх бүхий





этгээдийн нэрсийн жагсаалт;

6.6.2. тухайн барааны тэмдгийг гэрчлэх тэмдгээр бүртгүүлэх бол түүнийг ашиглах журам, гэрчлэх байгууллага мөн болохыг нотолсон баримт бичиг;

6.6.3. давамгайлах огноо хүссэн бол урьд гаргасан мэдүүлгийн хуулбар, эсхүл холбогдох нотлох баримт;

6.6.4. мэдүүлэг гаргагч нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлсэн бол итгэмжлэл.

6.7. Хэрэв хоёр буюу түүнээс дээш этгээд ижил барааны тэмдгийг ижил бараа, үйлчилгээнд ашиглаж байгаа бол хамгийн анх мэдүүлэг гаргасан этгээдийн барааны тэмдэг эзэмших эрх хамгаалагдана.

### **7 дугаар зүйл. Барааны тэмдгийн мэдүүлгийн бүрдлийг хянах, анхдагч огноог тогтоох**

7.1. Төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн бүрдлийн хяналтыг тухайн барааны тэмдгийн мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хийнэ.

7.2. Төрийн захиргааны байгууллага барааны тэмдгийн мэдүүлгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл мэдүүлгийг хүлээн авсан өдрөөр анхдагч огноог тогтоож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

7.3. Төрийн захиргааны байгууллага барааны тэмдгийн мэдүүлгийн бүрдэл хангагдаагүй гэж үзвэл энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэх бөгөөд мэдүүлэг гаргагч нь уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор зохих засварыг хийж ирүүлнэ.

7.4. Мэдүүлэг гаргагч нь зохих засварыг энэ хуулийн 7.3-т заасан хугацаанд хийж ирүүлсэн бол төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн анхдагч огноог түүнийг анх хүлээн авсан өдрөөр тогтоож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

7.5. Мэдүүлэг гаргагч нь зохих засварыг энэ хуулийн 7.3-т заасан хугацаанд хийж ирүүлээгүй бол төрийн захиргааны байгууллага мэдүүлэг гаргагчийг тухайн мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

7.6. Энэ хуулийн 6.6-д заасан зүйлийг мэдүүлгийн анхдагч огнооноос хойш хоёр сарын дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.



7.7. Энэ хуулийн 6.6-д заасан зүйлийг энэ хуулийн 7.6-д заасан хугацаанд ирүүлээгүй бол төрийн захиргааны байгууллага мэдүүлэг гаргагчийг тухайн мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

## **8 дугаар зүйл. Барааны тэмдгийн мэдүүлэгт шүүлт хийх**

8.1. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу барааны тэмдгийн мэдүүлгийн бүрдлийг хянаж, анхдагч огноог тогтоосны дараа тухайн барааны тэмдэг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхэд шүүлт хийж, дүгнэлт гаргана.

8.2. Төрийн захиргааны байгууллага шүүлтийг барааны тэмдгийн мэдүүлгийн анхдагч огнооноос хойш есөн сарын дотор хийх бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг зургаан сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

8.3. Төрийн захиргааны байгууллага тухайн барааны тэмдэг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл энэ тухай дүгнэлт гаргах ба түүнийг үндэслэн барааны тэмдгийг улсын бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргана.

8.4. Төрийн захиргааны байгууллага тухайн барааны тэмдэг нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл энэ тухай дүгнэлт гаргах ба түүнийг үндэслэн барааны тэмдгийг бүртгэхээс татгалзах тухай урьдчилсан шийдвэр гаргаж, мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

8.5. Мэдүүлэг гаргагч нь энэ хуулийн 8.4-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээж авснаас хойш гурван сарын дотор үндэслэл бүхий хариуг төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

8.6. Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 8.5-д заасан хариуг хүлээж авснаас хойш гурван сарын дотор тухайн барааны тэмдгийг бүртгэх эсэх талаар эцсийн шийдвэр гаргана.

8.7. Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 8.5-д заасан хариуг зохих хугацаанд ирүүлээгүй бол төрийн захиргааны байгууллага тухайн барааны тэмдгийг бүртгэхээс татгалзах тухай эцсийн шийдвэр гаргаж, мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

8.8. Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч барааны тэмдгийг өөрчлөхөөс бусад өөрчлөлтийг мэдүүлэгтээ оруулж болох ба барааны тэмдгийн мэдүүлэгт бараа, үйлчилгээний ангилал нэмэхээр бол шинээр



мэдүүлэг гаргана.

8.9.Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч бараа, үйлчилгээний нэгээс дээш ангилалд хамаарах барааны тэмдгийн мэдүүлгийг салгаж тус тусад нь гаргаж болно.

### **9 дүгээр зүйл. Барааны тэмдгийг бүртгэх, хэвлэх**

9.1.Төрийн захиргааны байгууллага барааны тэмдгийг бүртгэх шийдвэр гаргасан бол түүнийг барааны тэмдгийн улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоно.

9.2.Барааны тэмдгийн улсын бүртгэлд тухайн барааны тэмдгийн улсын бүртгэлийн дугаар, мэдүүлгийн бүртгэлийн дугаар, барааны тэмдэг эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, улсын нэр, барааны тэмдгийн дүрс, олон улсын ангиллын дагуу ангилсан тухайн барааны тэмдэгт хамаарах бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалт, анхдагч огноо, давамгайлах огноо, бүртгэлийн хүчинтэй байх хугацаа болон хамгаалагдаагүй үг, дүрсийн талаархи мэдээллийг заана.

9.3.Барааны тэмдгийн бүртгэл нь анхдагч огнооноос эхлэн 10 жилийн хугацаанд хүчинтэй байх бөгөөд барааны тэмдэг эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн бүртгэлийн хүчинтэй байх хугацааг тухай бүр 10 жилээр сунгаж болно.

9.4.Барааны тэмдгийн гэрчилгээ олгох, бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгахад Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд<sup>1</sup> заасан хэмжээгээр хураамж болон үйлчилгээний хураамж төлнө.

9.5.Төрийн захиргааны байгууллага нь бүртгэгдсэн барааны тэмдгийн ном зүй, дүрсийг энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

9.6.Бүртгэгдсэн барааны тэмдэг нь зөвхөн бүртгэл хийгдсэн бараа, үйлчилгээнд хамаарах ба энэ хуулийн 12.2-т заасан эзэмшигчийн хувьд хүчин төгөлдөр байна.

### **10 дугаар зүйл.Барааны тэмдгийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах**

10.1.Барааны тэмдгийн улсын бүртгэлд барааны тэмдэг эзэмшигчийн хүсэлтээр дараахь өөрчлөлтийг оруулна:

<sup>1</sup> Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1993 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн

- 10.1.1.бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгах;
- 10.1.2.барааны тэмдэг эзэмшигчийн нэр, хаягийг өөрчлөх;
- 10.1.3.барааны тэмдэг эзэмшигчийн эрхийг шилжүүлэх;
- 10.1.4.бараа, үйлчилгээний ангилал болон нэрсийн жагсаалтаас хасалт хийх.

10.2.Бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгуулах тухай хүсэлтийг тухайн бүртгэл хүчинтэй байх сүүлийн нэг жилийн дотор, эсхүл бүртгэлийн хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш зургаан сарын дотор төрийн захиргааны байгууллагад гаргаж болно.

10.3.Бүртгэлийн хүчинтэй байх хугацааг сунгахад барааны тэмдгийг өөрчлөхгүй бөгөөд бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалтад нэмэлт хийхгүй.

10.4.Барааны тэмдэг эзэмшигч өөрийн нэр, хаяг өөрчлөгдөх, эрх шилжүүлэх бүрт ийнхүү өөрчлөлт орсон өдрөөс хойш зургаан сарын дотор төрийн захиргааны байгууллагад бичгээр мэдэгдэн улсын бүртгэлд өөрчлөлт оруулна.

10.5.Төрийн захиргааны байгууллага барааны тэмдгийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулсан бол энэ тухай энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

## **11 дүгээр зүйл. Барааны тэмдгийн олон улсын бүртгэлтэй холбоотой асуудал**

11.1.Барааны тэмдгийн олон улсын мэдүүлгээр Монгол Улсын нэр зааж мэдүүлсэн барааны тэмдэгт шүүлт хийх, түүнийг бүртгэхэд энэ хуулийн 8-10 дугаар зүйлийн холбогдох заалтыг баримтална.

11.2.Барааны тэмдгийн олон улсын мэдүүлгээр Монгол Улсын нэр зааж мэдүүлсэн барааны тэмдгийн мэдүүлгийн анхдагч огноог олон улсын бүртгэлийн огноогоор, эсхүл нутаг дэвсгэрийн хүрээг өргөтгөх тухай хүсэлтийн огноогоор тогтооно.

11.3.Энэ хуульд заасны дагуу барааны тэмдгээ бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэхээр мэдүүлсэн Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, түүнчлэн Монгол Улсад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг болон байнга оршин суудаг аливаа этгээд уг барааны тэмдгийг Мадридын хэлэлцээр болон



Мадридын протоколын гишүүн улсад бүртгүүлэх хүсэлтэй бол мэдүүлгийг өөрөө, эсхүл оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн Олон улсын товчоонд гаргана.

11.4.Энэ хуулийн 11.3-т заасан мэдүүлгийн хувьд төрийн захиргааны байгууллага хүлээн авагч байгууллага байна.

11.5.Барааны тэмдгийн олон улсын мэдүүлэг гаргахад Мадридын хэлэлцээр, Мадридын протокол, Нийтлэг журамд заасныг баримтална.

11.6.Мэдүүлэг гаргагч нь барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн хугацааг сунгуулах, барааны тэмдэг эзэмшигчийн эрх шилжүүлэх, хүчингүй болгуулах, нутаг дэвсгэрийн хүрээг өргөтгөх тухай хүсэлтийг төрийн захиргааны байгууллагаар дамжуулан Олон улсын товчоонд гаргана.

11.7.Мэдүүлэг гаргагч нь барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн хураамжийг Нийтлэг журамд заасны дагуу Олон улсын товчоонд төлнө.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ БАРААНЫ ТЭМДЭГ ЭЗЭМШИГЧИЙН ОНЦГОЙ ЭРХ**

### **12 дугаар зүйл.Барааны тэмдэг эзэмшигчийн онцгой эрх**

12.1.Барааны тэмдэг эзэмшигчийн онцгой эрх тухайн барааны тэмдгийг улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

12.2.Барааны тэмдэг эзэмшигчийн онцгой эрх бүртгэгдсэн бараа, үйлчилгээний нэрсийн жагсаалтын хүрээнд үйлчилнэ.

12.3.Барааны тэмдэг эзэмшигч тухайн барааны тэмдгийн хувьд дараахь онцгой эрх эдэлнэ:

12.3.1.бүртгэгдсэн барааны тэмдгийг өмчлөх;

12.3.2.бүртгэгдсэн барааны тэмдгийг бусдад ашиглуулах;

12.3.3.бүртгэгдсэн барааны тэмдгийг бусдад шилжүүлэх;

12.3.4.бүртгэгдсэн барааны тэмдгийг бусад этгээд зөвшөөрөлгүйгээр ашигласан бол уг үйлдлийг таслан зогсоохыг шаардах;

12.3.5.бүртгэгдсэн барааны тэмдэгтэй төсөөтэй барааны тэмдгийг бусад этгээд ашигласан нь хэрэглэгчийг төөрөгдөлд оруулахаар бол уг үйлдлийг таслан зогсоохыг шаардах;



12.3.6.энэ хуулийн 12.3.4, 12.3.5-д заасан үйлдлээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах.

### **13 дугаар зүйл. Барааны тэмдгийг ашиглах**

13.1.Дараахь тохиолдолд барааны тэмдгийг ашигласанд тооцно:

13.1.1.барааны тэмдгийг бараа, түүний сав, баглаа боодол, үйлчилгээнд хэрэглэсэн бол;

13.1.2.барааны тэмдэг бүхий барааг нийлүүлсэн, худалдаанд гаргасан буюу энэ зорилгоор хадгалсан, үйлчилгээ үзүүлсэн бол;

13.1.3.барааны тэмдэг бүхий барааг хилээр нэвтрүүлсэн бол;

13.1.4.барааны тэмдгийг албан бичиг, танилцуулга, бусад баримт, интернэт, сурталчилгаанд ашигласан бол.

13.2.Барааны тэмдэг эзэмшигч нь барааны тэмдэг бүртгэгдсэнийг илэрхийлэх дугуй хүрээтэй "R" гэсэн латин үсэг бүхий таних тэмдгийн барааны тэмдгийн хамт хэрэглэж болно.

13.3.Барааны тэмдгийн оюуны бүтээлийн ертгийг тооцсон үнэлгээг хөрөнгийн баталгаа, барьцаа, хөрөнгө оруулалт болгох, хувьцаа гаргах, хувьчлал болон дуудлага худалдаанд оруулах, дүрмийн сан бүрдүүлэх, давтгалд хамруулах зэрэгт хэрэглэж болно.

13.4.Энэ хуулийн 13.3-т заасан зорилгоор гэрээ байгуулсан бол уг гэрээг төрийн захиргааны байгууллагад бүртгүүлнэ.

### **14 дүгээр зүйл. Хамтын тэмдгийг ашиглах**

14.1.Хамтын тэмдэг эзэмшигч нь тухайн хамтын тэмдгийг ашиглахад хяналт тавих этгээд байх бөгөөд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн нийгэмлэг, холбооны гишүүд хамтын тэмдгийг нэгдсэн хяналтын дор ашиглах эрхтэй.

14.2.Хамтын тэмдэг эзэмшигч болон ашиглагч нь тухайн хамтын тэмдгийг хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эрхтэй.

14.3.Хамтын тэмдэг эзэмшигч болон ашиглагч нь тухайн хамтын тэмдэг, түүнтэй төсөөтэй тэмдгийг хууль бусаар ашигласны улмаас учирсан



хохирлыг нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй.

### **15 дугаар зүйл. Гэрчлэх тэмдгийг ашиглах**

15.1.Гэрчлэх тэмдэг эзэмшигч нь тухайн бараа, үйлчилгээний онцлог шинж чанарыг гэрчлэх байгууллага байх бөгөөд зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд гэрчлэх тэмдгийг ашиглах эрхтэй.

15.2.Гэрчлэх тэмдгийг ашиглах эрхтэй этгээд нь гэрчлэх тэмдэг эзэмшигчийн зөвшөөрөлтэйгээр тухайн гэрчлэх тэмдгийг бусад этгээд хууль бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эрхтэй.

15.3.Гэрчлэх тэмдэг эзэмшигч нь гэрчлэх тэмдгийг ашиглах эрхтэй этгээдийн өмнөөс тухайн гэрчлэх тэмдэг, түүнтэй төсөөтэй тэмдгийг бусад этгээд хууль бусаар ашигласны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах эрхтэй.

15.4.Гэрчлэх тэмдэг нь газар зүйн заалтаас бүрдсэн бөгөөд барааны гарал үүслийг гэрчилж байвал уг гэрчлэх тэмдэгт энэ хуулийн газар зүйн заалтыг хамгаалахтай холбогдсон заалт нэгэн адил хамаарна.

### **16 дугаар зүйл. Барааны тэмдэг эзэмших эрхийг шилжүүлэх**

16.1.Барааны тэмдэг эзэмшигч нь барааны тэмдэг эзэмших эрх шилжүүлэх гэрээ байгуулсны үндсэн дээр уг эрхээ бусад этгээдэд шилжүүлж болох бөгөөд энэ нь бүртгэгдсэн барааны тэмдэгт хамаарах бүх, эсхүл зарим бараа, үйлчилгээнд хамаарч болно.

16.2.Барааны тэмдэг эзэмших эрх шилжүүлэх гэрээг төрийн захиргааны байгууллагад бүртгүүлж, барааны тэмдгийн улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулснаар барааны тэмдэг эзэмших эрх шилжсэнд тооцно.

16.3.Барааны тэмдэг эзэмших эрх шилжсэн тухай төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

### **17 дугаар зүйл. Барааны тэмдгийг бусдад ашиглуулах**

17.1.Барааны тэмдэг эзэмшигч нь бүртгэгдсэн барааны тэмдгийг бүх, эсхүл зарим бараа, үйлчилгээний хувьд лицензийн гэрээ байгуулсны үндсэн дээр бусад этгээдэд ашиглуулж болно.

17.2.Лицензийн гэрээг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг

зурж баталгаажуулах ба уг гэрээг төрийн захиргааны байгууллагад бүртгүүлснээр хүчинтэйд тооцно.

17.3.Лицензийн гэрээг бүртгүүлэхэд Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд заасан хураамж болон үйлчилгээний хураамж төлнө.

17.4.Лицензийн гэрээ байгуулагдсан тухай мэдээллийг төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

### **18 дугаар зүйл. Барааны тэмдэг эзэмших эрх дуусгавар болох**

18.1.Барааны тэмдэг эзэмшигчийн эрх дараахь үндэслэлээр дуусгавар болно:

18.1.1.барааны тэмдгийн бүртгэлийн хүчинтэй байх хугацаа дууссан бөгөөд уг хугацааг сунгуулах тухай хүсэлтийг энэ хуулийн 10.2-т заасан хугацаанд гаргаагүй бол;

18.1.2.барааны тэмдэг эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан бөгөөд эрх нь бусад этгээдэд шилжээгүй бол;

18.1.3.барааны тэмдэг эзэмшигч тухайн барааны тэмдгийн бүртгэлийг хүчингүй болгуулах тухай хүсэлт гаргасан бол;

18.1.4.хуульд заасан бусад үндэслэл.

18.2.Барааны тэмдэг эзэмшигчийн эрх дуусгавар болсон тохиолдолд төрийн захиргааны байгууллага нь энэ тухай энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ**

#### **19 дүгээр зүйл. Газар зүйн заалтын илэрхийлэгдэх хэлбэр**

19.1.Газар зүйн заалт нь тухайн бараа, бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлсон газар нутгийн газар зүйн нэр дангаараа, эсхүл тухайн бараа, бүтээгдэхүүний нэртэй хосолсон хэлбэрээр илэрхийлэгдэж болно.

#### **20 дугаар зүйл. Газар зүйн заалтад тавих шаардлага**

20.1.Дараахь зүйлийг газар зүйн заалтад тооцохгүй:





20.1.1.энэ хуулийн 3.1.4-т заасан тодорхойлолтод хамаарахгүй бол.

## 20.2. Дараахь газар зүйн заалтыг бүртгэхгүй:

20.2.1.газар зүйн заалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тухайн төрлийн бараа, бүтээгдэхүүний өрөнхий нэр болсон бол.

## 21 дүгээр зүйл. Газар зүйн заалтын мэдүүлэг гаргах

21.1.Газар зүйн заалтад хамаарч байгаа бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг нэгтгэсэн, газар зүйн заалт бүртгүүлэх хүсэлтэй нэгдэл, холбоо, байгууллага нь тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг төлөөлөх хуулиар олгосон эрхийн дагуу газар зүйн заалтыг бүртгүүлэхээр мэдүүлгийг төрийн захиргааны байгууллагын тогтоосон журмын дагуу бичгээр гаргана.

21.2.Газар зүйн заалтын мэдүүлгийг мэдүүлэг гаргагч өөрөө, эсхүл энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргана.

21.3.Газар зүйн заалтын мэдүүлэг зөвхөн нэг газар зүйн заалтад хамаарна.

## 21.4.Газар зүйн заалтын мэдүүлэг дараахь зүйлээс бүрдэнэ:

21.4.1.төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

21.4.2.энэ хуулийн 25.4-т заасны дагуу хураамж төлсөн тухай баримт.

## 21.5.Өргөдөлд дараахь зүйлийг тусгана:

21.5.1.газар зүйн заалтыг бүртгүүлэх тухай хүсэлт;

21.5.2.мэдүүлэг гаргагчийн оноосон нэр, хаяг, үүсгэн байгуулагдсан улсын нэр, үйл ажиллагаа явуулдаг улсын нэр, зохион байгуулалтын хэлбэр, эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдэг;

21.5.3.мэдүүлэг гаргагч нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж байгаа бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, гарын үсэг;

21.5.4.бүртгүүлэхээр мэдүүлж байгаа газар зүйн заалт;

21.5.5.тухайн газар нутгийн газар зүйн байршил;

21.5.6.газар зүйн заалт нь кириллээс өөр үсгээр илэрхийлэгдсэн бол тухайн газар зүйн заалтын кирилл үсгээр галигласан хөрвүүлэг, гадаад үгээр илэрхийлэгдсэн бол түүний орчуулга;

21.5.7.бараа, үйлчилгээний ангиллын дагуу ангилсан тухайн газар зүйн заалтад хамаарах бараа, бүтээгдэхүүний нэр;

21.5.8.бараа, бүтээгдэхүүний чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар нь тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, хүмүүсийн дадал заншилтай хэрхэн холбогдсон тухай тайлбар.

21.6.Газар зүйн заалтын мэдүүлэгт дараахь зүйлийг хавсаргана:

21.6.1.тухайн газар нутагт үйлдвэрлэл эрхэлдгийг нотолсон эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

21.6.2.бараа, бүтээгдэхүүний чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар нь тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, хүмүүсийн дадал заншилтай хэрхэн холбогдсон тухай эрх бүхий байгууллагын гаргасан дүгнэлт;

21.6.3.гадаад улсын газар зүйн заалтыг бүртгүүлэхээр мэдүүлж байгаа бол гарлын улсдаа газар зүйн заалтаар хамгаалагдсаныг нотолсон баримт;

21.6.4.мэдүүлэг гаргагч нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлсэн бол итгэмжлэл.

## **22 дугаар зүйл. Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт**

22.1.Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүн болохыг дараахь шинжээр тодорхойлно:

22.1.1.бараа, бүтээгдэхүүний нэр нь газар зүйн заалтаас бүрдсэн байх;

22.1.2.газар зүйн заалтад хамаарах бараа, бүтээгдэхүүний тодорхойлолт нь хими, физик, микробиологи, бүтцийн



шялж чанарыг агуулсан байх;

22.1.3.газар зүйн заалтад хамаарах газар зүйн бүс тодорхой байх;

22.1.4.газар зүйн заалтад хамаарах бараа, бүтээгдэхүүн нь тухайн газар нутгаас гарал үүсэлтэй болох нь нотлогдсон байх;

22.1.5.гарал үүсэл, хүний болон байгалийн хүчин зүйл, нутаг дэвсгэрийн онцлогтой холбогдож тухайн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг болох нь нотлогдсон байх;

22.1.6.тухайн бараа, бүтээгдэхүүнийг гаргаж авах, олж авдаг нутгийн үл өөрчлөгдөх, тогтвортой аргын талаархи тайлбар.

### **23 дугаар зүйл.Газар зүйн заалтын мэдүүлгийн бүрдлийг хянах, анхдагч огноог тогтоох**

23.1.Төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн бүрдлийн хяналтыг тухайн газар зүйн заалтын мэдүүлгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хийнэ.

23.2.Төрийн захиргааны байгууллага газар зүйн заалтын мэдүүлгийн бүрдэл хангагдсан гэж үзвэл түүнийг хүлээн авсан өдрөөр анхдагч огноог тогтоож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

23.3.Төрийн захиргааны байгууллага газар зүйн заалтын мэдүүлгийн бүрдэл хангагдаагүй гэж үзвэл энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэх бөгөөд мэдүүлэг гаргагч нь уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих засварыг хийж ирүүлнэ.

23.4.Мэдүүлэг гаргагч нь зохих засварыг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанд хийж ирүүлсэн бол төрийн захиргааны байгууллага мэдүүлгийн анхдагч огноог түүнийг анх хүлээн авсан өдрөөр тогтоож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

23.5.Мэдүүлэг гаргагч нь зохих засварыг энэ хуулийн 23.3-т заасан хугацаанд хийж ирүүлээгүй бол төрийн захиргааны байгууллага мэдүүлэг гаргагчийг тухайн мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

23.6.Энэ хуулийн 21.6-д заасан зүйлийг мэдүүлгийн анхдагч огнооноос хойш хоёр сарын дотор төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

23.7. Энэ хуулийн 21.6-д заасан зүйлийг энэ хуулийн 23.6-д заасан хугацаанд ирүүлээгүй бол төрийн захиргааны байгууллага мэдүүлэг гаргагчийг тухайн мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

#### **24 дүгээр зүйл. Газар зүйн заалтын мэдүүлэгт шүүлт хийх**

24.1. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу мэдүүлгийн бүрдлийн хяналт хийж, анхдагч огноог тогтоосны дараа тухайн газар зүйн заалт энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхэд шүүлт хийж, дүгнэлт гаргана.

24.2. Төрийн захиргааны байгууллага шүүлтийг мэдүүлгийн анхдагч огнооноос хойш зургаан сарын дотор хийх бөгөөд шаардлагатай гэж үзвэл энэ хугацааг зургаан сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

24.3. Төрийн захиргааны байгууллага тухайн газар зүйн заалт энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан гэж үзвэл энэ тухай дүгнэлт гаргах ба түүнийг үндэслэн газар зүйн заалтыг улсын бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргана.

24.4. Төрийн захиргааны байгууллага тухайн газар зүйн заалт энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл энэ тухай дүгнэлт гаргах ба түүнийг үндэслэн газар зүйн заалтыг бүртгэхээс татгалзах тухай урьдчилсан шийдвэр гаргаж, мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

24.5. Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 24.4-т заасан шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээж авснаас хойш гурван сарын дотор үндэслэл бүхий хариуг төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

24.6. Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 24.5-д заасан хариуг хүлээж авснаас хойш гурван сарын дотор тухайн газар зүйн заалтыг бүртгэх эсэх талаар эцсийн шийдвэр гаргана.

24.7. Мэдүүлэг гаргагч энэ хуулийн 24.5-д заасан хариуг зохих хугацаанд ирүүлээгүй бол төрийн захиргааны байгууллага тухайн газар зүйн заалтыг бүртгэхээс татгалзах тухай эцсийн шийдвэр гаргаж, мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

24.8. Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч газар зүйн заалтыг өөрчлөхөөс бусад өөрчлөлтийг мэдүүлэгтээ оруулж болно.



## **25 дугаар зүйл. Газар зүйн заалтыг бүртгэх, хэвлэх**

25.1.Төрийн захиргааны байгууллага газар зүйн заалтыг бүртгэх шийдвэр гаргасан бол түүнийг газар зүйн заалтын улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоно.

25.2.Газар зүйн заалтын улсын бүртгэлд тухайн газар зүйн заалтын улсын бүртгэлийн дугаар, мэдүүлгийн бүртгэлийн дугаар, хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, улсын нэр, газар зүйн заалт, бараа, үйлчилгээний ангиллын дагуу ангилсан тухайн газар зүйн заалтад хамаарах бараа, бүтээгдэхүүний нэр, анхдагч огноог заана.

25.3.Газар зүйн заалтын бүртгэл анхдагч огнооноос эхлэн хүчинтэй байх бөгөөд тодорхой хугацаагаар хязгаарлагдахгүй.

25.4.Газар зүйн заалтын гэрчилгээ олгоход Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд заасан хэмжээгээр хураамж болон үйлчилгээний хураамж төлнө.

25.5.Төрийн захиргааны байгууллага нь бүртгэгдсэн газар зүйн заалт, түүний ном зүйг нийтэд мэдээлэх зорилгоор энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ГАЗАР ЗҮЙН ЗААЛТ ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **26 дугаар зүйл. Газар зүйн заалт хэрэглэгчийн эрх, үүрэг**

26.1.Газар зүйн заалт хэрэглэгчийн эрх тухайн газар зүйн заалтыг улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

26.2.Газар зүйн заалт хэрэглэгчийн эрх бүртгэгдсэн бараа, бүтээгдэхүүнд хамаарна.

26.3.Газар зүйн заалт хэрэглэгч тухайн газар зүйн заалтын хувьд дараахь эрх эрхлэнэ:

26.3.1.өөрийн бараа, бүтээгдэхүүнд газар зүйн заалтыг ашиглах;

26.3.2.бүртгэгдсэн газар зүйн заалтыг бусад этгээд тухайн газар нутагт үйлдвэрлээгүй бараа, бүтээгдэхүүнд хэрэглэсэн бол уг үйлдлийг таслан зогсоохыг шаардах;



26.3.3.бүртгэгдсэн газар зүйн заалтыг бусад этгээд төсөөтэй бараа, бүтээгдэхүүнд хэрэглэснээс шударга бус давуу эрх эдлэх буюу газар зүйн заалтын нэр хүндийг гутаахаар бол уг үйлдлийг таслан зогсоохыг шаардах;

26.3.4.бүртгэгдсэн газар зүйн заалтыг бусад этгээд ашиглахдаа бараа, бүтээгдэхүүний гарал үүслийг үнэн зөвөөр заасан хэдий ч газар зүйн заалтыг хөрвүүлсэн байдлаар, эсхүл "төрлийн", "маягийн", "хийцийн", "дууриамал" зэрэг илэрхийллийн хамтаар ашигласан бол уг үйлдлийг таслан зогсоохыг шаардах;

26.3.5.энэ хуулийн 26.3.1-26.3.4-т заасан үйлдлээс учирсан хохирлыг нөхөн төлүүлэхийг шаардах.

26.4.Газар зүйн заалт хэрэглэгч нь тухайн бараа, бүтээгдэхүүний хувьд энэ хуулийн 21.6.2-т заасан дүгнэлтэд заасан чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанарыг хадгалах үүрэг хүлээнэ.

26.5.Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүн тухайн газар зүйн заалтын шинж чанарыг бүрэн агуулж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор чанарын дотоод болон гадны хяналт хийнэ.

26.6.Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүний чанарын дотоод хяналтыг газар зүйн заалт хэрэглэгч нэгдэл, холбоо, байгууллага хэрэгжүүлнэ.

26.7.Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүний гадны хяналтыг аймаг, нийслэлийн чанарын хяналтын лаборатори болон чанарын хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн байгууллага хэрэгжүүлнэ.

26.8.Газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүний чанарын хяналтын үр дүн нь энэ хуулийн 21.6.2-т заасан дүгнэлтэд тодорхойлсон шинж чанартай тохирч байвал тухайн бараа бүтээгдэхүүнийг газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүнд тооцно.

## **27 дугаар зүйл. Газар зүйн заалтыг ашиглах**

27.1.Дараахь тохиолдолд газар зүйн заалтыг ашигласанд тооцно:

27.1.1.газар зүйн заалтыг бараа, бүтээгдэхүүн, түүний сав, баглаа боодолд хэрэглэсэн бол;

27.1.2.газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүнийг



нийлүүлсэн, худалдаанд гаргасан буюу энэ зорилгоор хадгалсан бол;

27.1.3.газар зүйн заалт бүхий бараа, бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлсэн бол;

27.1.4.газар зүйн заалтыг албан бичиг, танилцуулга, бусад баримт, интернэт, сурталчилгаанд ашигласан бол.

27.2.Газар зүйн заалтыг өөрийн бараа, бүтээгдэхүүнд ашиглахаар бүртгүүлсэн этгээд нь тухайн газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд бүртгэгдсэн газар зүйн заалтыг энэ зүйлд заасны дагуу ашиглах эрхтэй.

### **28 дугаар зүйл. Газар зүйн заалт хэрэглэгчийн эрх дуусгавар болох**

28.1.Газар зүйн заалт хэрэглэгчийн эрх дараахь үндэслэлээр дуусгавар болно:

28.1.1.тухайн бараа, бүтээгдэхүүний чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар нь тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, хүмүүсийн дадал заншилтай шууд холбоогүй болсон бол;

28.1.2.газар зүйн заалт хэрэглэгч хуулийн этгээд татан буугдсан бол;

28.1.3.газар зүйн заалт хэрэглэгч нь тухайн газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгуулах тухай хүсэлт гаргасан бол;

28.1.4.хуульд заасан бусад үндэслэл.

28.2.Газар зүйн заалт хэрэглэгчийн эрх дуусгавар болсон тохиолдолд төрийн захиргааны байгууллага энэ тухай энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

### **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ОЮУНЫ ӨМЧИЙН БАЙГУУЛЛАГА**

#### **29 дүгээр зүйл.Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага**

29.1.Монгол Улсад барааны тэмдэг, газар зүйн заалттай холбогдсон асуудлыг төрийн захиргааны байгууллага хариуцах бөгөөд төрийн захиргааны байгууллага нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:



29.1.1.барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

29.1.2.барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулах;

29.1.3.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах, барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсонд тооцохтой холбоотой журам, дүрмийг боловсруулж, батлах;

29.1.4.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгүүлэх тухай өргөдлийн маягт болон барааны тэмдэг, газар зүйн заалтын гэрчилгээний загварыг тогтоох;

29.1.5.барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдүүлгийг хүлээн авч, хянах;

29.1.6.барааны тэмдэг, газар зүйн заалтыг бүртгэж, гэрчилгээ олгох;

29.1.7.барааны тэмдэг, газар зүйн заалтын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх;

29.1.8.барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

29.1.9.барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлтэй холбогдсон мэдээллийг нийтэд мэдээлэх зорилгоор энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэлэлд нийтлэх;

29.1.10.хуульд заасан үндэслэл, журмын дагуу барааны тэмдэг, газар зүйн заалтыг хүчингүй болсонд тооцох;

29.1.11.барааны тэмдгийн олон улсын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа явуулах;

29.1.12.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн биелэлтэд тавих улсын хяналтыг хэрэгжүүлэх, оюуны өмчийн улсын байцаагч ажиллуулах;

29.1.13.барааны тэмдэг, газар зүйн заалтын талаархи





сургалт, судалгааны ажлыг нэгдсэн арга зүйгээр хангаж, зохион байгуулах;

29.1.14.барааны тэмдэг, газар зүйн заалтын үнэлгээг эзэмшигч, хэрэглэгчийн хүсэлтээр баталгаажуулах;

29.1.15.оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажиллах этгээдийг шалгаруулах, тусгай зөвшөөрөл олгох;

29.1.16.хуулиар харьяалуулсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх;

29.1.17.хуульд заасан бусад чиг үүрэг.

29.2.Энэ хуулийн 6.4.2, 9.4, 17.3, 25.4-т заасан үйлчилгээний хураамжийн хэмжээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

### **30 дугаар зүйл.Оюуны өмчийн хяналтын улсын байцаагч, түүний бүрэн эрх**

30.1.Төрийн захиргааны байгууллагад оюуны өмчийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч ажиллана.

30.2.Төрийн захиргааны байгууллагын дарга оюуны өмчийн хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

30.3.Оюуны өмчийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрхийг Засгийн газар, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

30.4.Оюуны өмчийн хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ оюуны өмчийн хяналтын чиглэлээр Төрийн хяналт шалгалтын тухай<sup>4</sup>, Захиргааны хариуцлагын тухай хууль<sup>5</sup> болон бусад хууль тогтоомжид заасан нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

30.5.Улсын байцаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан гагцхүү хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгон

<sup>4</sup> Төрийн хяналт шалгалтын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн

<sup>5</sup> Захиргааны хариуцлагын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн



ажиллана.

30.6.Улсын байцаагч хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд, албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

30.7.Улсын байцаагчийн хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлаар бусад этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

### **31 дүгээр зүйл. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч**

31.1.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дээд боловсролтой, оюуны өмчийн салбарт гурваас доошгүй жил ажилласан, 25 насанд хүрсэн, Монгол Улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн, эсхүл Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд байна.

31.2.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд<sup>6</sup> заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл авна.

31.3.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажиллах журмыг төрийн захиргааны байгууллага батална.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ ГОМДОЛ, ХҮСЭЛТ, МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ**

### **32 дугаар зүйл. Гомдол хүсэлт, маргааныг шийдвэрлэх**

32.1.Төрийн захиргааны байгууллагын дэргэд барааны тэмдэг, газар зүйн заалттай холбоотой дор дурдсан гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэх эрх бүхий Маргаан шийдвэрлэх комисс ажиллана:

32.1.1.энэ хуулийн 7, 8, 23, 24 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаатай холбоотой гарсан мэдүүлэг гаргагчийн гомдол;

32.1.2.бүртгэгдсэн барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг энэ хуулийн 33.1.1-д заасан үндэслэлээр хүчингүй болгуулах тухай хүсэлт;

32.1.3.бүртгэгдсэн барааны тэмдгийн бүртгэлийг энэ

<sup>6</sup> Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн



хуулийн 33.1.2-т заасан үндэслэлээр хүчингүй болгуулах тухай хүсэлт;

32.1.4.тухайн барааны тэмдэг нь нийтэд түгээмэл болсон барааны тэмдэг мөн эсэхийг хүлээн зөвшөөрүүлэх тухай хүсэлт.

32.2.Энэ хуулийн 32.1.1-д заасан гомдлыг мэдүүлэг гаргагч мэдэгдэл хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор Маргаан шийдвэрлэх комисст гаргана.

32.3.Энэ хуулийн 32.1.2, 32.1.3-т заасан хүсэлтийг бүртгэгдсэн барааны тэмдэг, газар зүйн заалт энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлд хэвлэгдсэнээс хойш нэг жилийн дотор Маргаан шийдвэрлэх комисст гаргана.

32.4.Маргаан шийдвэрлэх комисс нь энэ хуулийн 32.1-д заасан гомдол, хүсэлтийг хүлээж авснаас хойш зургаан сарын дотор хянан шийдвэрлэж энэ тухай гомдол, хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

32.5.Маргаан шийдвэрлэх комиссын гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдол, хүсэлт гаргагч гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

32.6.Маргаан шийдвэрлэх комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг оюуны өмчийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

#### **33 дугаар зүйл. Барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгох**

33.1.Барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг дараахь үндэслэлээр хүчингүй болгоно:

33.1.1.барааны тэмдэг, газар зүйн заалтыг энэ хуулийн 5, 20 дугаар зүйлийг зөрчиж бүртгэсэн бол;

33.1.2.барааны тэмдэг нь Парисын конвенцийн гишүүн аль нэг улсад тухайн барааны тэмдгийн хувьд онцгой эрх эзэмшигч этгээдийн зөвшөөрөлгүйгээр түүний төлөөлөгч, эсхүл бараа, бүтээгдэхүүнийг борлуулагч этгээдийн нэр дээр бүртгэгдсэн бол.

33.2.Сонирхогч этгээд энэ хуулийн 33.1.1, 33.1.2-т заасан үндэслэлээр бүртгэгдсэн барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгуулах хүсэлтийг Маргаан шийдвэрлэх комисст гаргана.



33.3.Маргаан шийдвэрлэх комисс нь үндэслэлтэй гэж үзвэл бүртгэгдсэн барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргаж, энэ тухай төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

33.4.Төрийн захиргааны байгууллага дараахь тохиолдолд өмнө бүртгэсэн барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг тухайн эзэмшигч, хэрэглэгчийн хувьд хүчингүй болсонд тооцно:

33.4.1.барааны тэмдгийн гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссанаас хойш зургаан сарын дотор хугацаа сунгуулах тухай хүсэлт гаргаагүй;

33.4.2.барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгч нь бүртгэгдсэн барааны тэмдгийг эзэмших, газар зүйн заалтыг хэрэглэх эрхээсээ татгалзсан тухай бичгээр мэдэгдсэн;

33.4.3.барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгч хуулийн этгээд татан буугдсан бөгөөд уг барааны тэмдгийг эзэмших, газар зүйн заалтыг хэрэглэх эрхийг өөр этгээдэд шилжүүлээгүй буюу барааны тэмдгийг лицензийн гэрээгээр ашиглуулаагүй.

33.5.Төрийн захиргааны байгууллага нь барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийг хүчингүй болгосон тухай энэ хуулийн 3.1.14-т заасан албан ёсны тогтмол хэвлэлээр нийтэд мэдээлнэ.

#### **34 дүгээр зүйл.Барааны тэмдэг эзэмшигчийн эрх, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага**

34.1.Барааны тэмдэг эзэмшигчийн эрх, газар зүйн заалт хэрэглэгчийн эрх зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч, улсын байцаагч иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас хорин тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл шүүгч гэм буруутай иргэн, албан тушаалтныг 7-14 хоногоор баривчлах шийтгэл ногдуулж, улсын байцаагч, шүүгч нь зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлсийг хураан авч, хууль бусаар олсон орлогыг улсын орлого болгон тухайн барааг устгаж, үйл ажиллагааг зогсооно.

34.2.Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нохон төлөх асуудлыг Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

34.3.Барааны тэмдэг, газар зүйн заалтыг хууль бусаар ашигласны



улмаас хураан авсан зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг борлуулах, хэрэглээнд буцаан гаргах нь барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчиж болзошгүй гэж шүүх болон төрийн захиргааны байгууллага үзвэл түүнийг устгах тухай шийдвэрийг гаргах бөгөөд бусад тохиолдолд хураагдсан бараа, бүтээгдэхүүнийг улсын орлого болгох, устгах асуудлыг нийтлэг журмын дагуу зохион байгуулна.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**ДДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2010 оны 06 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.13.1 дэх заалтын "зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн" гэснийг "оюуны өмчийн" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.13.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**ДДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2010 оны 06 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ПАТЕНТИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Патентийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн гарчиг, 27.1-27.4 дэх хэсгийн "Патентийн" гэснийг "Оюуны өмчийн" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2010 оны 06 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАР ЗҮЙН  
ЗААЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ  
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2003 оны 5 дугаар сарын 2-ны өдөр баталсан Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2010 оны 06 дугаар  
сарын 10-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар  
хот

**Монголбанкны Хяналтын зөвлөлийн  
дарга, гишүүдийг чөлөөлөх,  
томилох тухай**

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27<sup>1</sup> дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсонтой холбогдуулан Самбуугийн Дэмбэрэл, Дэмчигжавын Моломжамц, Дуламсүрэнгийн Нямаа, Жигжидийн Үнэнбат, Чимидийн Энхбаатар нарыг Монголбанкны Хяналтын зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2. Монголбанкны Хяналтын зөвлөлийн даргаар Жигжидсүрэнгийн Ядамсүрэнг, гишүүнээр Жигжидийн Үнэнбат, Хуягийн Ганбаатар, Ямааранзын Эрхэмбаяр, Дэмчигжавын Моломжамц, Чимидийн Энхбаатар, Дуламсүрэнгийн Нямаа нарыг тус тус томилсугай.

3. Энэ тогтоолыг 2010 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Д.ДЭМБЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 4 дүгээр  
сарын 14-ний өдөр

Дугаар 90

Улаанбаатар  
хот

### Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх I үе шатны төлөвлөгөө (2010-2015 он)"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, салбар дундын зохицуулалт хийх үүрэг бүхий Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шалгарчлан баталж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт үүрэг болгосугай.

3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, Сангийн сайд С.Баярцогт, холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/ хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах мөнгөнийг эхл бүрэлдэх үийгэм, өдрийн сангай: хэргүүдэл: үндсэн чиглэл, төсөвт тусган санхүүжүүлж хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай;

б/ хөтөлбөрийн зарим арга хэмжээг олон улсын байгууллагын зээл, тусламж, гадгад оронтой тогтоосон хоёр болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр, төлөвлөгөө батлах



тухай” Засгийн газрын 2003 оны 6 дугаар сарын 4-нөй өдрийн 141 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**С.БАТБОЛД**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Л.ГАНСҮХ**

Засгийн газрын 2010 оны 90 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## **ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

#### **1. Нэр томъёо**

Энэхүү хөтөлбөрт хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.1. “Цөлжилт” гэж НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцид “уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаа зэрэг олон янзын хүчин зүйлийн нөлөөгөөр хуурай, хуурайвтар, чийг дутмаг нутаг оронд газрын доройтол болох”-ыг тодорхойлсныг;

1.2. “Цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сваруулах” гэж цөлжих эрсдэлтэй газар нутгийг цөлжилтөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, элсний нүүдлийг зогсоох, уул уурхайн нөхөн сэргээлт хийх, тариалангийн талбайн хөрс хамгаалах, усалгааны систем, ойн зурвас байгуулах, бэлчээрийн даацыг тохируулах болон цөлжиж байгаа газар нутгийг нөхөн сэргээх, мод, бут тарих, ургамалжуулах, усан сан байгуулах, гангийн нөлөөг бууруулах зэрэг үйл ажиллагааг;

1.3. “Гангийн нөлөөг бууруулах” гэж цөлжилттэй тэмцэх ажлын хүрээнд ганг урьдчилан мэдээлэх, нийгэм, байгаль орчныг гангийн нөлөөллөөс хамгаалах үйл ажиллагаа зэргийг.

#### **2. Монгол орны цөлжилтийн төлөв байдал**

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенци (цаашид “ЦТК” гэх)-ийн тодорхойлолтыг үндэслэн тооцвол Монгол Улсын нийт бэлчээрийн 90 орчим хувь нь цөлжилт, газрын доройтлын үйл явцад өртөх магадлалтай нутагт хамрагдах бөгөөд эдгээрээс үнэлгээ, зураглалын өнөөгийн үр





дүнгээр цөлжилтийн нэн хүчтэй зэрэглэлд 5.0 хувь, хүчтэй зэрэглэлд 18.0 хувь, дунд зэрэглэлд 26.0 хувь, сул зэрэглэлд 23.0 хувь нь тус тус хамрагдах болжээ. Энэ нь тодорхой бүс нутагт цөлжилтийн аюулын зэрэглэл нэмэгдэж, нутаг дэвсгэрийн 72 хувь хүртэл өргөжсөн байгааг харуулж байна.

Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд Увс нуурын хотгор, Их нууруудын хотгор, Нууруудын хөндий, Дундговь, Дорноговийн гандуу хуурай, цөлөрхөг нутгууд ихэвчлэн хамрагдаж байна. Говь, хээрийн бүсийн 145 сумын төв суурин газар элсний нүүдэлд өртсөн байна.

### 3. Монгол орны цөлжилт, газрын доройтолд нөлөөлж байгаа хүчин зүйлс

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан манай оронд 1940-2007 онд агаарын жилийн дундаж температур 2.1°C-аар дулаарч, бүх нутгаар дулаарах хандлагатай болжээ. Дулаарлын үйл явцын нөлөөн дор жилийн нийлбэр хур тундасны хэмжээ нутгийн төв, өмнөд хэсгүүдэд бага хэмжээгээр буурч байна.

Хур тундасны хэмжээнээс гадна зуны хур борооны шинж байдал өөрчлөгдөн томоохон нутаг хамарсан зүс бороо орох тохиолдол багасч, ихэвчлэн түр зуурын аадар бороо зурвас газраар орох болжээ. Эрдэмтдийн судалгаагаар хуурайшил тал хээр, говь цөлийн бүсэд олон жилийн дунджаас 3.2-10.0 хувь, ой хээрийн бүс, өндөр уулын бүслүүрт 10-15 хувиар нэмэгдсэн байна. Дулааны улиралд агаарын температур огцом нэмэгдэж, хур тундас буурч байгаа нь байгалийн өнөөгийн хуурайшил, гандалтын гол шалтгаан юм.

Манай орны бүх бүс нутагт ган, зуд тохиолдох магадлалтай бөгөөд хуурай болон хуурайвтар бүс нутагт гол төлөв давтамж өндөртэй байна. Тал хээр, говийн бүсийн нутагт шороон шуургатай өдрийн тоо 1960 онтой харьцуулахад 3-4 дахин өсч, говь болон Их нууруудын хотгорт жилийн 61-127 өдөр нь шороон шуургатай байна. Энэ нь элсний нүүлт ихсэх, цөлжилт нэмэгдэх хүчин зүйл болж байна.

Уур амьсгалын өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр гадаргын усны хэмжээ эрчимтэй буурсан нь цөлжилтөд нөлөөлж байна. Газрын уст цэгийн 2007 оны мэдээг 1970 оныхтой харьцуулахад нийт 887 гол, горхи, 2096 булаг шанд, 1166 нуур, тойром хатаж ширгэсэн байна.

Монгол орны хувьд бэлчээрийн талхлагдал нь цөлжилт, газрын доройтлын үндсэн хүчин зүйл болж байна. Энэ нь бэлчээрийн газрыг ашиглах талаархи бодлого, зохицуулалт муу байгаагийн үр дагавар юм.



Монгол Улсын мал сүрэг сүүлийн жилүүдэд тогтвортой өсч, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын тайлан мэдээнд дурдсанаар бэлчээрийн даац 32.5 хувиар буюу 16 сая хонин толгойгоор хэтэрсэн байна. Сүргийн бүтцэд гарсан өөрчлөлтийн улмаас ямааны тоо олцом өсч, нийт сүргийн 46 хувийг эзлэх болсон нь бэлчээрийн талхагдлын бас нэг гол шалтгаан болж байна.

1970-аад оноос говийн бүсийн төв суурин газрын түлшний хэрэгцээнд заг модыг их хэмжээгээр хавтгайруулан бэлтгэдэг болсноос 125.0 мянган га газрын заг бүрэн устаж, 370 гаруй мянган га газрын заг байгалийн аясаар сэргэж ургах чадвараа алдаж, цөлжилт идэвхжих нэг гол шалтгаан болжээ. Мөн олон салаа авто зам гарч, уул уурхайн зориулалтаар газрыг ухаж сэндийлэх, тариалангийн талбайг элэгдэл эвдрэлд оруулах зэргээр хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан цөлжилтийн илрэлүүд эрчимжиж байна.

#### 4. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах шаардлага, үндэслэл

2010-2020 онд хэрэгжүүлэх Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулах болсон үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлж байна:

4.1. XXI зуунд цөлжилт, газрын доройтолтой холбоотой нийгэм, эдийн засгийн хүндрэлтэй асуудлууд хүн төрөлхтөний өмнө тулгараад байна. Цөлжилт, газрын доройтол, биологийн төрөл зүйлийн хомсдол, уур амьсгалын нөлөөг бууруулахад иргэдийн оролцоог бүрэн хангасан шинэ бодлого, үйл ажиллагааг боловсруулан хэрэгжүүлэх, цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулахад шинжлэх ухаан, техник, технологийн дэвшлийг ашиглах, мэдлэгийг бий болгох нь чухал байна. Энэ нь зөв тодорхойлогдсон зорилго, зорилт, урт хугацааны зохистой төлөвлөлт чухал шаардлагатайг харуулж байна.

4.2. 2007 онд болсон НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Талуудын 8 дугаар бага хурлаас Цөлжилттэй тэмцэх 10 жилийн стратегийг; 2009 онд болсон НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Талуудын 9 дүгээр бага хурлаас 2010-2020 оныг цөлжилттэй тэмцэх 10 жил болгох шийдвэрийг тус тус батлан гаргасан бөгөөд энэхүү стратеги, баримт бичигт тусгагдсан зорилт, үйл ажиллагаатай уялдуулж конвенцийн Талууд өөрийн үндэсний хөтөлбөрийг боловсруулах талаар нэгдсэн ойлголтод хүрсэн;

4.3. Хөтөлбөрийг Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлого зэрэг тулгуур баримт бичгүүдийн үзэл санаатай уялдуулан боловсруулах



шаардлагатай байна. 2009 оны 5 дугаар сард Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар Монгол орны цөлжилтийн явц, шалтгаан, түүний эрчийг сааруулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашдын зорилтын тухай илтгэлийг хэлэлцээд гаргасан зөвлөмжид Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг Үндэсний хөгжлийн цогц бодлоготой уялдуулан шинэчлэн боловсруулах чиглэл гаргасан.

## **Хоёр. Хөтөлбөрийн зорилго, тэргүүлэх чиглэл, зорилтууд, хэрэгжүүлэх зарчим, үйл ажиллагаа, хугацаа**

### **5. Нийтлэг зорилт, бодлогод оруулах хувь нэмэр**

Монгол Улсын Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь цөлжилттэй тэмцэх талаар олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хүлээсэн үүргийг биелүүлэх болон дараахь нийтлэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн болно:

5.1. Тогтвортой хөгжлийн үзэл санааг үндэсний хөгжлийг хангах бодлого, хөтөлбөрт тусгах замаар байгаль орчны доройтлыг бууруулах талаар байгаль орчны тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн Мянганы хөгжлийн 7 дугаар зорилт;

5.2. Хөдөөгийн хөгжил, хөдөө аж ахуйн салбарын хөгжил, ус, ой, байгалийн нөөцийг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн чиглэлээрх зорилтуудыг хэрэгжүүлэх талаар Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого;

5.3. Цөлжилттэй тэмцэх конвенцийн 10 жилийн (2008-2018) стратеги, НҮБ-аас 2010-2020 оныг Дэлхийн цөлжилттэй тэмцэх 10 жил болгон зарласантай холбогдсон бодлого, үйл ажиллагаа.

### **6. Хөтөлбөрийн эрхэм зорилго**

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн эрхэм зорилго нь цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх замаар байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, цөлжилтөд өртсөн нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд оршино.

### **7. Энэхүү эрхэм зорилгод хүрэхийн тулд дараахь тэргүүлэх чиглэлийг тодорхойлж байна:**

7.1. Байгууллагын чадавхийг бэхжүүлэх;

7.2. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;



7.3. Шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээг өргөжүүлэх;

7.4. Сурталчилгаа, оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих;

7.5. Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

#### 8. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

8.1. Бодлого тодорхойлох, шийдвэр гаргахдаа олон нийт, иргэдийн оролцоонд түшиглэх;

8.2. Салбар дундын хамтын ажиллагааг хангах;

8.3. Нутгийн захиргаа, иргэдийн хамтын ажиллагааны орон нутгийн байгалийн нөөцийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах;

8.4. Иргэдийн шууд оролцоог хангах урамшуулалттай байх;

8.5. Цөлжилт, газрын доройтлын аюул нүүрлээд байгаа газарт хөрөнгө оруулалтыг түлхүү чиглүүлэх, доройтлын хэм хэмжээ өндөртэй нутагт иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, бодит үр ашиг бий болгох үйл ажиллагааг дэмжин ажиллах;

8.6. Цөлжилтөөс нүүдлийн соёл иргэншилд үзүүлэх хор хөнөөлийн хохирогч нь хүн өөрөө гэдгийг иргэн бүрт ойлгуулах.

#### 9. Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд дараахь зорилтыг тавьж байна:

9.1. "Байгууллагын чадавхийг бэхжүүлэх" тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь үр дүнд хүрнэ:

9.1.1. Зорилт 1. Цөлжилттэй тэмцэх үндэсний хороог хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган уялдуулан, зохицуулах чадавхитай болгох чиглэлээр шинэчлэн зохион байгуулж ажиллуулна;



#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.1.1.1. Цөлжилттэй тэмцэх үндэсний хороог салбар хоорондын ажлын уялдааг хангаж чадахуйц бүрэлдэхүүнтэй болгон шивчлэх;

9.1.1.2. байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны орон тооны ажлын албыг байгуулж ажиллуулах;

9.1.1.3. үндэсний хорооны ажлын алба болон орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудал хариуцсан удирдлага, мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх.

9.1.2. Зорилт 2. Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар цөлжилттэй тэмцэх талаар Засгийн газраас дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг салбарын болон орон нутгийн бодлого, хөтөлбөр, төсөвт тусган үр дүнтэй хэрэгжүүлж тайлагнана.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.1.2.1. яамд салбарын бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээндээ цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг тусган хэрэгжүүлж тайлагнадаг байх;

9.1.2.2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг өөрийн хариуцсан ажлын хүрээнд цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохион байгуулж тайлагнах;

9.1.2.3. аймаг, нийслэл, сум, дүүрэг цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах;

9.1.2.4. хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг хариуцсан яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагын үр дүнгийн гэрээнд цөлжилттэй тэмцэх ажлыг тусган дүгнэдэг болох.

9.1.3. Зорилт 3. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг иргэд, хувийн хэвшил, улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө болон гадаад орон, олон улсын байгууллагын тусламж, дэмжлэгээр бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.1.3.1. цөлжилттэй тэмцэхэд шаардлагатай санхүүгийн болон техник, технологийн нөөцийг бүрдүүлэх;

9.1.3.2. цөлжилттэй тэмцэх ажилд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байх;

9.1.3.3. цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах чиглэлээр олон улсын байгууллага болон гадаад орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

9.1.3.4. төр, хувийн хэвшлийн түншлэлийг байгаль хамгаалах, цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах чиглэлээр хөгжүүлэх.

9.1.4. Зорилт 4. Боловсон хүчний чадавхийг сайжруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.1.4.1. цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны ажлын албаны болон орон нутаг дахь менежерүүдийн чадавхийг бэхжүүлэх;

9.1.4.2. цөлжилт, газрын доройтлын төлөв байдалд хяналт-шинжилгээ хийх, чиг хандлагад үнэлгээ өгөх, цөлжилттэй тэмцэх технологи, арга барилыг боловсруулах, баримтжуулах, технологи дамжуулах эрдэм шинжилгээний байгууллагын чадавхийг гадаадын тусламжаар хэрэгжүүлж байгаа төслүүдийн дэмжлэгтэйгээр бэхжүүлэх;

9.1.4.3. цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, сэргийлэх уламжлалт мэдлэг, шинэ арга барил, дэвшилтэт технологийн талаар иргэдэд зориулсан сургалт зохион байгуулах, сурталчилгаа явуулах.

9.2. “Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох” тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь үр дүнд хүрнэ:

9.2.1. Зорилт 1. Цөлжилттэй тэмцэх, сэргийлэх, цөлжилтийг сааруулах хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгосон байна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:



9.2.1.1. цөлжилттэй тэмцэхэд байгалийн нөөцийн тогтвортой менежментийг бүрдүүлэх суурь нөхцөл болох байгаль ашиглагчдын эрх, үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэх хөшүүргийг бодлого, хууль эрх зүйн түвшинд тодорхойлох;

9.2.1.2. хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар хуулийн төсөл боловсруулах;

9.2.1.3. салбар дундын зохицуулалтыг бодлого, хууль эрх зүйн баримт бичигт тусгах;

9.2.1.4. газрын элэгдэл, эвдрэл, цөлжилтийн төрөл, ангилал, зэрэглэлийг тогтоох журам боловсруулж мөрдөх.

9.3. "Шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээг өргөжүүлэх" тэргүүлэх чиглэлийн зорилтын хүрээнд дараахь үр дүнд хүрнэ:

9.3.1. Зорилт 1. Цөлжилтийн үндэсний нэгдсэн мэдээллийн сантай болно.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.3.1.1. цөлжилт, газрын доройтлын чиг хандлагыг үнэлэх арга зүйг шинэчлэн тодорхойлох;

9.3.1.2. цөлжилтөд өртсөн нутгийн биофизикийн болон нийгэм, эдийн засгийн суурь үнэлгээг хийх;

9.3.1.3. цөлжилт, газрын доройтлын төлөв байдал, цаашдын хандлагын талаархи мэдээллийн нэгдсэн сан байгуулах.

9.3.2. Зорилт 2. Цөлжилт хүнтэй болон нэн хүнтэй илэрсэн бүс нутагт цөлжилт, цөлжилтийн үйл явцыг судлах хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээ байгуулагдана.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.3.2.1. ган, цөлжилт, газрын доройтлын хяналт-шинжилгээний нэгдсэн мэдээллийн сан бий болгох;

9.3.2.2. ган, цөлжилт, газрын доройтлын байдалд



хяналт-шинжилгээ хийх аргачлалыг боловсронгуй болгох;

9.3.2.3. үндэсний хэмжээний хяналт-шинжилгээний сүлжээг байгуулах.

9.3.3. Зорилт 3. Цөлжилтийн судалгааны төвд цөлжилт, газрын доройтлыг сааруулах технологи, арга барилын мэдээллийн сан бүрдүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.3.3.1. шинжлэх ухаанд суурилсан шийдвэр гаргах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор цөлжилт, газрын доройтлын суурь хүчин зүйл, тэдгээрийн үр нөлөөний талаархи мэдлэг, мэдээллийг бий болгох;

9.3.3.2. цөлжилттэй тэмцэх ажлыг шинжлэх ухааны мэдлэг, технологитой уялдуулах зорилгоор олон улсын, үндэсний болон уламжлалт технологи, арга барилыг турших, баримтжуулах, нийтэд түгээх ажлыг эрчимжүүлэх.

9.4. "Сурталчилгаа, оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих" тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь үр дүнд хүрнэ:

9.4.1. Зорилт 1. Бүх шатны боловсролын түвшинд тогтвортой хөгжлийн боловсролыг эзэмшүүлэх ажлын хүрээнд байгаль экологийг доройтуулж байгаа болон цөлжилтийг үүсгэж байгаа хүчин зүйл, хор уршгийн талаархи мэдлэгийг хүүхэд, залуучуудад эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.4.1.1. НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын "Тогтвортой хөгжлийн боловсролын арван жил" хөтөлбөрийн үзэл санааг ерөнхий боловсролын хөтөлбөрт тусгах;

9.4.1.2. байгальд ээлтэй сургууль болохыг дэмжих замаар сурагч, багш, эцэг эхийн байгаль орчныг хамгаалах сэтгэлгээг төлөвшүүлэх.

9.4.2. Зорилт 2. Цөлжилтийг нэмэгдүүлж байгаа шалтгаан, хүчин зүйл, үр дагаврын талаархи мэдлэгийг дээшлүүлэх, цөлжилттэй тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мэдээллээр хангана.





Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.4.2.1. цөлжилт, түүнд хүргэж байгаа хүчин зүйлсийн талаархи олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг мэдээллийн бүхий л хэрэгслээр сургалт, сурталчилгаа, ярилцлага зэрэг арга хэлбэрээр тогтмол зохион байгуулах;

9.4.2.2. цөлжилттэй тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний хийж байгаа ажлыг урамшуулах, дэмжихэд чиглэсэн олон нийтийн арга хэмжээг зохион байгуулах.

9.4.3. Зорилт 3. Бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчдад шинжлэх ухаанд үндэслэсэн мэдээллийг хүргэх замаар зохистой шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.4.3.1. цөлжилттэй тэмцэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бодлого, хууль, эрх зүйн орчинг сайжруулах зорилгоор бодлого тодорхойлогч, шийдвэр гаргагчдыг үнэн зөв мэдээллээр тогтмол хангаж тэдний мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж шийдвэр гаргахад зөв нөлөө үзүүлэх.

9.5. "Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх" тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь үр дүнд хүрнэ:

9.5.1. Зорилт 1. Орон нутгийн түвшинд байгаль хамгаалал, байгалийн нөөц ашиглалтын менежментийг боловсронгуй болгох, бодит арга хэмжээг зохион байгуулах замаар цөлжилтийг сааруулна.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.5.1.1. орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор газрын боломжит нөөцийн зохистой ашиглалтыг хангаж чадахуйц газар зохион байгуулалтын төлөвлөлтийг шинэчлэн бэлтгэснээр;

9.5.1.2. орон нутгийн усны ашиглалтыг оноочтой болгох зорилгоор доройтол илэрсэн болон эрсдэл өндөртэй газар нутагт усны нөөцийн нэгдсэн менежментийн хэрэгжилтийг хангах;

9.5.1.3. цөлжилтийн дунд (25.9 хувь), сул зэрэглэлд (22.8 хувь) хамрах газруудад цөлжилтөөс урьдчилан сэргийлэх,



сааруулах арга хэмжээний хүрээнд хот, суурин болон орон нутгийн зам, тээвэр зэрэг дэд бүтцийн салбарт байгальд ээлтэй арга технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжих;

9.5.1.4. цөлжилтийн нэн хүчтэй (5 хувь), хүчтэй (18.5 хувь) зэрэглэлд хамрагдах газруудад мод тарих, ургамалжуулах, хөв цөөрөм байгуулах, нийгмийн чухал ач холбогдолтой дэд бүтэц, барилга байгууламж, суурин газрыг элсний нүүлт хөдөлгөөн, газрын элэгдэл, эвдрэлээс хамгаалах бодит арга хэмжээг зураг төсөл, төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулах;

9.5.1.5. говь, цөлийн бүсэд байгалийн баянбүрдийг хамгаалах, сэргээх ажлыг төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулах;

9.5.1.6. эрчим хүчний бусад эх үүсвэрүүд (ахуйн хэрэглээний хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, сум, суурин газрыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох зэрэг)-ийг бий болгосноор гандуу бүс нутгийн мод, бут сөөг, ургамлыг түлшний зориулалтаар ашиглаж байгааг хязгаарлах.

9.5.2. Зорилт 2. Байгалийн нөөц ашиглагчдын бүлгүүд, байгаль хамгаалагчдын нөхөрлөлүүдэд байгалийн нөөцийг зохистой ашиглах эрх, үүргийн тогтолцоог бий болгох замаар байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө (бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, усны менежментийн төлөвлөгөө, ойн менежментийн төлөвлөгөө зэрэг)-г хэрэгжүүлнэ.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.5.2.1. бэлчээрийн даацад тохируулан зохистой ашиглах зорилгоор бэлчээр ашиглагчдын бүлгүүдийн үүрэг, хариуцлагын тогтолцоог бий болгох;

9.5.2.2. усны сав газрын зөвлөлүүдийг байгуулж, ажиллах нөхцөлийг нь бүрдүүлэх;

9.5.2.3. орон нутагт малчид, малтай байсан иргэдэд орлогын нэмэлт эх үүсвэр бий болгож байгальд үзүүлэх дарамтыг багасгах;

9.5.2.4. ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг доройтол илэрсэн болон эрсдэл өндөртэй газар нутгийг нөхөн сэргээхэд чиглүүлж дэмжих.



9.5.3. Зорилт 3. Үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжлийн нөлөөгөөр доройтолд орсон газар нутгийг нөхөн сэргээхэд байгалийн нөөц, баялаг ашиглаж байгаа иргэдийн оролцоог нэмэгдүүлж "нөөц ашиглагч төлөх" зарчмыг нэвтрүүлнэ;

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

9.5.3.1. уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн байгаль орчинд ээлтэй арга, технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжих;

9.5.3.2. уурхайн зориулалтаар ашигласан газар нутгийг нөхөн сэргээх журамд "нөөц ашиглагч төлөх" зарчмыг тусгаж шинэчлэн боловсруулах, энэ чиглэлээр мэргэжлийн зөвлөмж, зөвлөгөө өгөх;

9.5.3.3. авто зам барих томоохон төсөл хөтөлбөрүүдийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх;

9.5.3.4. авто зам барихад ашигладаг байгаль орчинд ээлтэй шинэ арга, технологийг турших, нэвтрүүлэх.

9.5.4. Зорилт 4. Цөлжилтөд өртсөн бүс нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг бусад хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй нягт уялдуулан, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, амьдрах орчныг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг нэмэгдүүлэх.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

9.5.4.1. Биологийн төрөл зүйлийг хамгаалах үндэсний хөтөлбөртэй харилцан уялдуулан биологийн төрөл зүйлийн хомсдол, цөлжилтөд хүргэж байгаа нөхцөлийг бууруулах арга хэмжээ авах;

9.5.4.2. биологийн төрөл зүйлийн амьдрах орчныг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

9.5.4.3. уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөртэй уялдуулан цөлжилт, түүнээс үүдэлтэй байгалийн гамшгийн нөлөө болон эрсдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

9.5.4.4. цэвэр хөгжлийн механизм, Даян дэлхийн байгаль хамгаалах сан зэрэг эх үүсвэрүүдээс газрын тогтвортой



менеджментийг дэмжих санхүүгийн дэмжлэг олох, хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

9.5.4.5. байгалийн баялгийг ашиглахаас татгалзсан, байгалийн баялгийн ашиглалтыг орлуулсан орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх санаачилгыг дэмжих.

## 10. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

10.1. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь 2010-2020 оны хооронд дараахь хоёр үе шаттайгаар хэрэгжинэ:

10.1.1. Нэгдүгээр үе шат (2010-2015 он)-нд цөлжилттэй тэмцэх ажлын эрх зүйн орчин, зохион байгуулалтыг сайжруулах, цөлжилттэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх, цөлжилттэй тэмцэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн цогц бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

10.1.2. Хоёрдугаар үе шат (2016-2020 он)-нд цөлжилтөд хүчтэй өртсөн эмзэг бүс нутгийн доройтсон орчныг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх замаар цөлжилтийн эрчийг сааруулах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

## 11. Эрсдэл болон урьтал нөхцөлүүд

11.1. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь дараахь урьтал нөхцөлүүд бүрэлдсэн байхыг шаардана:

11.1.1. байгалийн нөөцийг зохицуулалтгүй ашиглах, түүнээс үүдэн гарах хохирлыг даван туулах улс төрийн болон олон нийтийн сонирхол байх;

11.1.2. уур амьсгал, цаг агаарын тааламжгүй он жилүүд урт хугацаанд үргэлжилж давагдашгүй хүчин зүйл бий болохоос урьдчилан сэргийлэх;

11.1.3. улс орны санхүү, эдийн засгийн нөхцөл улам бүр сайжирч, хөтөлбөр хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байх;

11.1.4. олон улсын байгууллагууд уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, биологийн төрөл зүйлийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж байх.



## Гурав. Оролцогч талууд, тэдгээрийн үүрэг

12. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь оролцогч талуудын идэвхтэй оролцоонд түшиглэн хэрэгжинэ. Хөтөлбөрт тусгасан тэргүүлэх чиглэл, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа шийдвэрлэх үүрэгтэй байна.

13. Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо нь дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

13.1. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах;

13.2. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулах;

13.3. Цөлжилттэй тэмцэх зорилгоор салбарын болон салбар дундын бодлого, хууль, эрх зүйн орчинд шинэтгэл хийхэд оролцох;

13.4. Бодлого тодорхойлох, шийдвэргаргах болон мэдээллийн хэрэгслээр цөлжилттэй тэмцэх талаар мэдлэг, мэдээлэл дамжуулах үйл ажиллагаанд оролцох;

13.5. Цөлжилтөд нөлөөлөх гол хүчин зүйлийн хяналт-шиножилгээний тайланг 2 жил тутамд; цөлжилтийн зэрэглэлийн болон нийгэм, эдийн засгийн үнэлгээний тайлан, зураглалыг 5 жил тутам холбогдох мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж Засгийн газарт танилцуулах;

13.6. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газарт танилцуулж, нийтэд мэдээлэх.

14. Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллага дараахь тэргүүлэх үүрэгтэй:

14.1. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

14.1.1. цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

14.1.2. цөлжилтийн төлөв байдлыг хянах хяналт-шиножилгээний сүлжээг зохион байгуулах;

14.1.3. хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхтэй холбогдуулан эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

14.1.4. говь, хээрийн болон цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутагт унаган ургамлыг тарималжуулах, ойг нөхөн сэргээх тогтвортой менежментийг бий болгох;

14.1.5. уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх;

14.1.6. ус хэмнэлтийн бодлого, тухайлбал, хур тундас нэмэгдүүлэх, ус хуримтлуулах, хиймэл нуур, цөөрөм, хөв байгуулах, говийн баянбүрдийг хамгаалах, сэргээх замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

14.1.7. цөлжилтөөс сэргийлэхэд онцгой ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэх;

14.1.8. хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүрэг.

14.2. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.2.1. цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээг газрын тогтвортой менежмент, газар зохион байгуулалтын бодлого, төлөвлөгөө, үйл ажиллагаагаар дамжуулан зохион байгуулж тайлагнах;

14.2.2. авто замын оновчтой сүлжээг бий болгож хөрсний элэгдэл, эвдрэлээс сэргийлэх;

14.2.3. хот, суурин газрын төлөвлөлтөд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх бодлогыг тусгаж хэрэгжүүлэх.

14.3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.3.1. хөрсний элэгдэл, эвдрэлд сөрөг нөлөө багатай ойн зурвас бүхий газар тариалан эрхлэх бодлого, үйл ажиллагааг зохион байгуулах;

14.3.2. бэлчээрийн тогтвортой менежментийг зохион



байгуулж, хэрэгжүүлэх;

14.3.3. бэлчээрийн даацад тохирсон мал сүргийн оновчтой бүтцийг бий болгох төрийн бодлогыг шинэчлэн тодорхойлж хэрэгжүүлэх.

14.4. Сангийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.4.1. газрын доройтол, хөрсний элэгдэл, цөлжилттэй тэмцэх ажилд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт тусгах;

14.4.2. цөлжилттэй тэмцэх ажилд гадаад орон, олон улсын байгуулагын зээл, тусламж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

14.5. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага цөлжилттэй тэмцэх ажилд зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг зохион байгуулан оролцуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

14.6. Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Шинжлэх ухааны академи дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.6.1. хүүхэд залуучуудад байгаль, экологи, цөлжилт, байгаль орчны доройтлын сөрөг үр дагаврын талаар сургалтын хөтөлбөрт тусгах;

14.6.2. байгаль хамгаалах уламжлалт арга, цөлжилт, байгаль орчны доройтлын сөрөг үр дагаврын талаархи мэдлэгийг зайн сургалтаар олгох;

14.6.3. Улсын Их Хурал, Засгийн газар, шийдвэр гаргагчдыг цөлжилт, газрын доройтлын талаархи шинжлэх ухааны ололт, бодит мэдээллээр хангах;

14.6.4. газрын доройтол, цөлжилттэй тэмцэх уламжлалт арга болон дэвшилтэт технологийг боловсруулж нэвтрүүлэх.

14.7. Эрдэс баялаг, эрчим хүчний асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.7.1. сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх бодлого боловсруулж үйл ажиллагааг зохион байгуулах;

14.7.2. хий болон бусад эрчим хүчний шинэ эх үүсвэрийн талаар судалгаа, хэрэглээг нэмэгдүүлэх бодлогыг цөлжилттэй тэмцэх ажилтай уялдуулан явуулах;

14.7.3. эрдэс баялгийн хайгуул болон ашиглалтын явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, нөхөн сэргээх хариуцлагатай уул уурхайн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

15. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар аймаг, сумын Засаг дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.1. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх асуудлыг хариуцан зохион байгуулах;

15.2. Засаг дарга үйл ажиллагааны хөтөлбөртөө цөлжилттэй тэмцэх асуудлыг тусгасан байх;

15.3. Цөлжилттэй тэмцэх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх;

15.4. Байгалийн нөөц ашиглагчдын эрх, үүргийг тодорхойлж байгаль ашиглагчдын бүлгийг бүртгэх, тэдгээрийн менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд нь хяналт тавих;

15.5. Орон нутгийн төсвийн тодорхой хэсгийг байгаль ашиглагч болон хамгаалагчдын бүлгүүдээр дамжуулан байгаль хамгаалах ажилд зарцуулах.

16. Эрдэм шинжилгээ, судалгааны холбогдох байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.1. газрын доройтол, цөлжилтийн төлөв байдал, цаашдын хандлагыг судлан тогтоож холбогдох мэдээллээр хангах;

16.2. байгальд ээлтэй технологи, арга барилыг орон нутаг нэвтрүүлэх, цөлжилт, газрын доройтлын хүчин зүйлс, тэдгээрийн байгаль орчин, иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөлөлд хяналт-шинжилгээ хийх;

16.3. цөлжилтийн судалгааны төв нь шийдвэр гаргагч, бодлого тодорхойлогч, байгалийн нөөц ашиглагчдад газрын тогтвортой менежментийн технологи, арга барилын мэдээлэл түгээж, технологи, арга барилын талаархи мэдээллийг цуглуулах, баримтжуулах ажлыг Дэлхийн Байгаль хамгаалах технологи, арга барилын тойм (WOCAT) нийтлэг арга





зүйд суурилан үндэсний мэдээллийн сан байгуулах.

17. Байгаль хамгаалах чиг үүрэг бүхий иргэний нийгмийн байгууллага нь цөлжилттэй тэмцэхэд орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэд, олон нийтэд сурталчилгаа хийх, байгалийн баялаг ашиглагчдад хяналт тавих үүрэг хүлээнэ.

18. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр нь олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн дараахь үйл ажиллагаанд хамтран оролцохыг чухалчилна:

18.1. Цөлжилттэй тэмцэх олон улсын төсөл, хөтөлбөрийн сүлжээнд хамрагдах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцоход дэмжлэг үзүүлэх;

18.2. Холбогдох үндэсний байгууллага (Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо, Цөлжилтийн судалгааны төв зэрэг)-уудын боловсон хүчний болон бүтэц, зохион байгуулалтын чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

18.3. Цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, гангийн нөлөөг бууруулах зорилго бүхий төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

18.4. Цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах чиглэлээрх технологи, арга барилыг туршиж ашиглахад дэмжлэг үзүүлэх;

18.5. Туршигдсан технологи, арга барилыг өргөн хүрээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

### **Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт**

19. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, салбар дундын зохицуулалтаар хангах, хяналт тавих үүрэг бүхий Цөлжилттэй тэмцэх үндэсний хороог байгаль эрчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүнэ.

20. Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны дүрэм, үйл ажиллагааны төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21. Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо нь хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх өөрийн төсөвтэй байна.



22. Холбогдох яам, аймаг, нийслэлийн Засаг дарга Цөлжилттэй тэмцэх үндэсний хороонд жил бүр үйл ажиллагаагаа тайлагнах үүрэгтэй.

23. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг улсын төсөв, тусгай сан, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, гадаадын зээл, буцалтгүй тусламжаас бүрдүүлнэ.

**Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах тогтолцоо, үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт**

24. Хөтөлбөрийн хэрэгжилтээс гарах үр дүнгийн хяналт-шинжилгээг тэргүүлэх чиглэл тус бүрээр хийнэ.

25. Тэргүүлэх чиглэлийн зорилт бүрт харгалзах шалгуур үзүүлэлтүүдийг дараахь хүснэгтээр үзүүлэв:

Тэргүүлэх чиглэл	Тэргүүлэх чиглэлийн зорилтууд	Хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд
Байгууллагын чадавхийг бэхжүүлэх	Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалтыг сайжруулах	Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажлын албаны чиг үүргийг тодорхойлсон сайдын шийдвэр
	Цөлжилттэй тэмцэх ажилд оролцох байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх	Цөлжилттэй тэмцэх чиглэлд холбогдох байгууллагуудаас хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн жагсаалт
Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Салбарын болон салбар дундын бодлого, хууль эрх зүйн баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтийг уялдуулах	Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн Засгийн газар, Улсын Их Хурлаар батлагдсан хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт



Шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээг өргөжүүлэх	Шийдвэр гаргах түвшинд тайлагнахад шаардлагатай мэдээ мэдээлэлд суурилсан мэдлэгийн суурийг бүрдүүлэх	Шийдвэр гаргах түвшинд байгаль орчны төлөв байдал, ялангуяа цөлжилт, газрын доройтол, цаашдын хандлагын талаар хүргүүлсэн мэдээ мэдээлэл
	Цөлжилтийг сааруулах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай технологи, мэдлэгийн суурийг бий болгох	Монгол Улсад нэвтрүүлсэн технологи, арга барилын тоо
Сурталчилгаа, оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих	Цөлжилттэй тэмцэхэд шийдвэр гаргагчид болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	Иргэд, шийдвэр гаргагчдын мэдлэг, зан үйлд гарсан өөрчлөлт тусгайлсан судалгааны үзүүлэлтээр
	Боловсролоор дамжуулан байгаль орчны талаархи хүүхэд, залуучуудын сэтгэлгээг өөрчлөх	Тогтвортой хөгжлийн боловсролын зарчмыг агуулсан ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөр
Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	Газрын тогтвортой менежментийн арга хэлбэрийг дэмжих замаар газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг урт хугацаанд хангах нөхцөлийг бүрдүүлэх	-Орон нутгийн байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцооны түвшин; -Байгалийн нөөц ашиглагчдын бүлгүүдийн дунд илэрсэн сонирхлын зөрчилдөөний тоо, хандлага; -Бэлчээр ашиглагчдын бүлэгт хамрагдсан малчин өрхийн тоо; -Менежментийн төлөвлөгөөний дагуу албан ёсны бүлэг, нөхөрлөлүүдийн ашиглаж байгаа газрын хэмжээ



	Байгаль ашиглагчдын оролцоог хангасан байгалийн нөөцийн тогтвортой менежментийн арга, хэрэгслийг хөгжүүлэх	-Ус ашиглагчдад усны нөөцийг тэнцвэртэй хангасан байдал; -Ой бүхий талбайн өөрчлөлт (ойжуулсан, шинээр ой үүсгэсэн, огтолсон, түймэрт шатсан); -Зэрлэг амьтдын амьдрах орчны талбайн өөрчлөлт.
	Аж үйлдвэрлэлийн хөгжил, дэд бүтцийн салбарт байгальд ээлтэй арга туршлагыг нэвтрүүлэх	-Үйлдвэрлэл, дэд бүтцэд өртсөн болон нөхөн сэргээгдсэн талбай; -Экологийн цэвэр үйлдвэрлэлийн технологи нэвтрүүлсэн үйлдвэр, албан нэгжийн тоо
	Цөлжилт, газрын доройтолд хүргэх уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг сааруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бүхий л үүсгэл санаачилгад дэмжлэг үзүүлэх	-Ургамлан нөмрөгийг нөхөн сэргээсэн талбай;  -Байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдсэн талбай.

26. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээг үйл ажиллагааны зорилтын түвшинд тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийг суурь мэдээ, зорилтот нөхцөл, гарах үр дүнгийн тоон утгыг үе шат тус бүрт нийцүүлэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

27. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үр дүнд өгөх үнэлгээг яамдын холбогдох газар, эрдэм шинжилгээний байгууллага, хөндлөнгийн шинжээчид хэрэгжүүлэх бөгөөд Цөлжилттэй тэмцэх үндэсний хороо нь хяналт-шинжилгээ, Үр дүнг Засгийн газар, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлэх үндэсний тайланд тусгана.

**ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ I ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (2010-2015 ОН)**

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Оролцогч талууд	
			Хариуцах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
Тэргүүлэх чиглэл 1: Байгууллагын чадавхийг бэхжүүлэх				
1.1. Цөлжилттэй тэмцэх үндэсний хороог хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохицуулах чадавхитай болгон шинэчлэн зохион байгуулж ажиллуулна				
1.1.1	Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах	2010	БОАЖЯ	ЦТҮХ
1.1.2	Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны орон тооны ажлын алба болон орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтыг оновчтой болгох	2010-2012	БОАЖЯ	ЦТҮХ
1.2. Яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар цөлжилттэй тэмцэх талаар Засгийн газраас дэвшүүлсэн зорилт, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг салбарын болон орон нутгийн бодлого, хөтөлбөр, төсөвт тусган үр дүнтэй хэрэгжүүлж тайлагнана				
1.2.1	Холбогдох яамд бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөндөө цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийн зорилт үйл ажиллагааны чиглэлийг тусган хэрэгжүүлж тайлагнах	2010-2015	ЦТҮХ	Яамд

1.2.2	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болон бусад байгууллагууд өөрийн үйл ажиллагааныхаа хүрээнд цөлжилттэй тэмцэх ажлыг хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлж, тайлагнах	2010-2015	ЦТҮХ	Агентлаг, бусад байгууллагууд
1.2.3	Аймаг, нийслэл, сум, дүүрэг цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг тайлагнах	2010-2015	ЦТҮХ	Бүх шатны Засаг дарга
1.2.4	Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагын үр дүнгийн гэрээнд цөлжилттэй тэмцэх ажлыг тусган дүгнэдэг болгох	2010-2015	БОАЖЯ	Яам, агентлаг, бүх шатны Засаг дарга
1.3. Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэр болон техник, технологийн нөөцийг бүрдүүлэх				
1.3.1	Цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байх	2010-2015	СЯ, БОАЖЯ	ХХААХҮЯ, БХЯ, ЗТБХБЯ, ЭБЭХЯ, БСШУЯ бусад холбогдох яамд
1.3.2	Цөлжилттэй тэмцэхэд шаардлагатай техник, технологийн нөөцийг бүрдүүлэх	2010-2015	БОАЖЯ, ЦТҮХ	БСШУЯ, ЭБЭХЯ, ХХААХҮЯ, ЗТБХБЯ, ШУА
1.3.3	Олон улсын байгууллага, гадаадын болон дотоодын төсөл, хөтөлбөрүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2010-2015	ЦТҮХ, ГХЯ	Холбогдох яамд, төсөл, хөтөлбөрүүд

1.3.4	Төр, хувийн хэвшлийн түншлэлийг байгаль хамгаалах, цөлжилттэй тэмцэх, сааруулах чиглэлээр хөгжүүлэх	2010-2015	ЦТҮХ	БОАЖЯ, ЦТҮХ, холбогдох бусад яам, агентлагууд
1.4. Боловсон хүчний чадавхийг сайжруулах				
1.4.1	Цөлжилттэй тэмцэх үндэсний хорооны ажлын албан ёсо болосон хүчнийг менежмент, төлөвлөлт, үйл ажиллагааны мониторингийн сургалтад хамруулан сургах	2010-2015	БОАЖЯ	ЦТҮХ
1.4.2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн байгаль орчны асуудал харуулсан мэргэжилтнүүдэд зориулсан цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	2010-2015	ЦТҮХ	БСШУЯ, бүх шатны Засаг дарга, ШУА
1.4.3	Эрдэм шинжилгээний байгууллагуудын эрдэмтэн судлаачид болон мэргэжилтнүүдийг цөлжилт, түүний чиг хандлагад мониторинг хийх, үнэлгээ болон цөлжилттэй тэмцэх арга барил, технологи боловсруулах чиглэлээр олон улсын эрдэм шинжилгээний төвүүдтэй холбоо тогтоох, хамтарсан эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэх, олон улсын хурал болон сургалтуудад хамруулах	2010-2015	БОАЖЯ, ЦТҮХ	БСШУЯ, ШУА, төсөл, хөтөлбөрүүд
1.4.4	Цөлжилттэй тэмцэх уламжлалт мэдлэг, дэвшилтэт технологи, арга барилыг иргэд, олон нийтэд дэлгэрүүлэх, сурталчлах	2010-2015	БОАЖЯ, ЦТҮХ	ШУА, хэвлэл, мэдээллийн байгууллагууд

Тэргүүлэх чиглэл 2. Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

2.1. Цөлжилттэй тэмцэх, сэргийлэх, цөлжилтийг сааруулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох

2.1.1	Байгаль ашиглагчдын эрх үүрэг, тэдгээрийг хэрэгжүүлэх хөшүүргийг бодлого, хууль, эрх зүйн түвшинд тодорхойлж, холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах	2010-2015	БОАЖЯ	ХХААХУЯ, ЗТБХБЯ
2.1.2	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх талаар хууль боловсруулж, батлуулах	2011	БОАЖЯ	ХЗДХЯ, ХХААХУЯ, ЗТБХБЯ
2.1.3	Газрын элэгдэл, эвдрэлийн зэрэглэл, цөлжилтийн төрөл, ангиллыг тогтоох журам боловсруулж мөрдөх	2010	БОАЖЯ	ХХААХУЯ, ЗТБХБЯ, ШУА
2.1.4	Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон газрын нөхөн сэргээлт хийх журмыг шинэчлэн боловсруулах	2010-2015	БОАЖЯ	ХХААХУЯ, ЗТБХБЯ, ШУА
2.1.5	Батлагдсан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах зорилгоор шинээр гарсан хуулиудыг хэвлэн нийтлүүлэх, хуулийг хэрэгжүүлэгч байгууллагад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	2010-2015	БОАЖЯ	ХЗДХЯ, ЦТҮХ, төсөл, хөтөлбөрүүд

Тэргүүлэх чиглэл 3. Шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээг өргөжүүлэх

3.1. Цөлжилтийн үндэсний нэгдсэн мэдээллийн сантай болох

3.1.1	Цөлжилтийн цар хүрээ, чиг хандлагыг үнэлэх арга зүйг шинэчлэн тодорхойлох	2010	БОАЖЯ	ШУА, төсөл, хөтөлбөрүүд
3.1.2.	Цөлжилтөд өртсөн нутгийн биофизикийн болон нийгэм, эдийн засгийн суурь үнэлгээг хийх	2010	БОАЖЯ	БСШУЯ, ШУА, төсөл, хөтөлбөрүүд





3.1.3	Цөлжилтийн чиглэлээр хийгдэх судалгаа, шинжилгээний ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх нэгдсэн бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх	2010-2015	ЦТҮХ	БСШУЯ, ШУА, төсөл, хөтөлбөрүүд
3.1.4	Цөлжилт, газрын доройтлын төлөв байдал, цаашдын хандлагын талаархи мэдээллийн сан байгуулах	2010-2015	БОАЖЯ	ЦТҮХ, ШУА, төсөл, хөтөлбөрүүд
3.2. Цөлжилт, цөгжилтийн үйл явцыг судлах хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээ байгуулах				
3.2.1	Газрын хөрс, ургамлан бүрхэвчийн доройтол, цөлжилтийн үйл явцыг судлах хяналт-шинжилгээний суурин сүлжээ байгуулж, байнгын үйл ажиллагааг хангах	2010-2015	БОАЖЯ	ЦУОШГ, ШУА
3.2.2	Цэвдгийн үргэлжилсэн тархацтай бүсэд цэвдгийн хяналт-шинжилгээний сүлжээ байгуулахад дэмжлэг үзүүлэх	2010-2015	БОАЖЯ	ЦУОШГ, ШУА
3.3. Цөлжилт, газрын доройтлыг сааруулах, технологийг, арга барилын мэдээллийн сан бүрдүүлнэ				
3.3.1	Ган, газрын доройтол, цөлжилтийн сөрөг үр дагавар нь иргэдийн амьжиргаанд нөлөөлөх байдлын судалгаа, шинжилгээг үндэсний хэмжээнд хийх	2010-2015	БОАЖЯ	ШУА, төсөл, хөтөлбөрүүд
3.3.2	Цөлжилт, газрын доройтлын суурь хүчин зүйлс, тэдгээрийн үр дагаврын талаархи мэдлэг мэдээллийг бий болгох	2010-2015	БОАЖЯ	БСШУЯ, ЦТҮХ, ШУА, төсөл, хөтөлбөрүүд
3.3.3	Дэлхийн хөрс, ус хамгаалах (WOCAT) арга зүйн дагуу цөлжилттэй тэмцэх арга барил, технологийг туршиж, баримтжуулах мэдээллийн сан (MONCAT)-г боловсронгуй болгох	2010-2015	ЦТҮХ	ШУА, төсөл, хөтөлбөрүүд, ТББ

3.3.4	Цөлжилт, газрын доройтлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээллийг нийгмийн бүх шатанд түгээх ажлыг эрчимжүүлэх	2010-2015	ЦТҮХ	ШУА, төсөл, хөтөлбөрүүд, ТББ
Тэргүүлэх чиглэл 4. Сурталчилгаа, оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих				
4.1. Байгаль, экологийг доройтуулж байгаа болон цөлжилтийг үүсгэж байгаа хүчин зүйл, хор уршгийн талаархи мэдээллийг хүүхэд, залуучуудад эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх				
4.1.1	НҮБ-ын боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын "Тогтвортой хөгжлийн боловсролын арван жил" хөтөлбөрийн үзэл санааг ерөнхий боловсролын хөтөлбөрт тусгах	2010-2015	БСШУЯ	БОАЖЯ, ШУА, их, дээд сургуулиуд
4.1.2	Байгаль хамгаалах уламжлалт зан үйл, ёс заншил, арга замын талаар сургалт, сурталчилгаа явуулах багш нарыг үе шаттайгаар бэлтгэх	2010-2015	БСШУЯ	ШУА, их, дээд сургуулиуд
4.1.3	Байгальд ээлтэй, байгаль орчны чиглэлээр сургалт явуулдаг тусгай сургалттай сургуулиудын үйл ажиллагааг дэмжих	2010-2015	БСШУЯ	БОАЖЯ
4.2. Цөлжилтийг нэмэгдүүлж байгаа шалтгаан, хүчин зүйл, үр дагаврын талаархи мэдээллийг дээшлүүлэх, цөлжилттэй тэмцэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор мэдээллээр хангах				
4.2.1	Байгаль орчныг хамгаалах, цөлжилтийн төлөв байдал, чиг хандлага, цөлжилтийг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлүүд, учруулж буй хохирол болон цөлжилтөөс урьдчилан сэргийлэх боломжийн талаархи мэдээллийг олон нийтэд хэвлэл, мэдээллийн бүх хэрэгсэл ашиглан хүргэх ажлыг тогтмолжуулах	2010-2015	БОАЖЯ, ЦТҮХ, БСШУЯ	Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлүүд, ТББ

4.2.2	Цөлжилттэй тэмцэх хандлагыг өөрчлөн шинэчилж, цөлжилтийг сааруулахад идэвх саналчилгатай ажиллаж байгаа иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудыг урамшуулан дэмжих, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах	2010-2015	БОАЖЯ	ЦТҮХ, ТББ
4.2.3	Дэлхийн цөлжилттэй тэмцэх өдрийг жил бүр тодорхой сэдвийн хүрээнд иргэд, олон нийтэд зориулан мэдээлэл түгээх зорилгоор уулзалт, ярилцлага болон олон нийтийг хамарсан бусад арга хэмжээг зохион байгуулах	2010-2015	БОАЖЯ	ЦТҮХ, ШУА, төсөл, хөтөлбөрүүд, ТББ
4.2.4.	Албан бус боловсролын зайны сургалтын тогтолцоог ашиглан цөлжилтийн талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах	2010-2015	БСШУЯ	БОАЖЯ, ЦТҮХ
4.3. Бодлого тодорхойлолч, шийдвэр гаргагчдад шөжлөх ухаанд үндэслэсэн мэдээллийг хүргэх замаар зохистой шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлнэ				
4.3.1	Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийг холбогдох шатны байгууллага, албан тушаалтнуудад сурталчлан ойлгуулснаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх	2010-2015	БОАЖЯ	Холбогдох яамд, ЦТҮХ, төсөл, хөтөлбөрүүд
4.3.2	Бүх түвшний удирдах ажилтнуудад зориулан цөлжилтийн төлөв байдал, чиг хандлага, цөлжилтийг нэмэгдүүлж байгаа хүчин зүйлүүд, учруулж буй хохирлын талаархи мэдээллээр хангах, тэдний гаргах бодлого, шийдвэрт зөв нөлөө үзүүлэх	2010-2015	БОАЖЯ	ЦТҮХ, ШУА, төсөл, хөтөлбөрүүд

Тэргүүлэх чиглэл 5. Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх

5.1. Орон нутгийн түвшинд байгаль хамгаалал, байгалийн нөөц ашиглалтын менежментийг боловсронгуй болгох, бодит арга хэмжээг зохион байгуулах замаар цөлжилтийг сааруулна

5.1.1	Орон нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор газрын боломжит нөөцийн зохистой ашиглалтыг хангаж чадахуйц газар зохион байгуулалтын төлөвлөлтийг шинэчлэн боловсруулах	2010-2015	ЗТБХБЯ	ГХБГЗЗГ, төсөл, хөтөлбөрүүд
5.1.2	Газрын нэгдмэл сангийн оновчтой төлөвлөлтөд үндэслэсэн газар, түүний хэвлийн баялгийг зохистой ашиглах, хамгаалах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх	2010-2015	ЗТБХБЯ	ГХБГЗЗГ, төсөл, хөтөлбөрүүд
5.1.3	Уламжлалт бэлчээр ашиглах аргыг сэргээх, орон нутагт бэлчээр сэлгэх, өнжөөх, хашаалах ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх	2010-2015	ХХААХУЯ	ЗТБХБЯ, Бүх шатны Засаг дарга, төсөл, хөтөлбөрүүд, ТББ
5.1.4	Хадлангийн талбайг хөшиж хамгаалах, га-гаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, хоршоо, бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх	2010-2015	ХХААХУЯ	Бүх шатны Засаг дарга, төсөл, хөтөлбөрүүд
5.1.5	Хуурай, хуурайвтар бүс нутагт иргэд санаачилгаараа усны нөөцөө ашиглан тэжээлийн ургамал тариалах ажилд дэмжлэг үзүүлэх	2010-2015	ХХААХУЯ	ТББ

5.1.6	"Атрын II аян"-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд хөрсийг элэгдлээс хамгаалж хөрсний чанарыг бууруулахгүй байх зорилгоор тариалангийн талбайд ойн зурвас байгуулах ажлыг дэмжих	2010-2015	ХХААХУЯ	Хувийн хэвшлийн байгууллага
5.1.7	Газар тариалангийн үйлдвэрлэлд техник, технологийн шинэчлэл хийх ажлыг эрчимжүүлж, хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах технологийг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлэх	2010-2015	ХХААХУЯ, ЗТБХБЯ	Хувийн хэвшлийн байгууллага
5.1.8	Доройтсон газрын хэмжээ, байршил, элэгдлийн зэрэглэлийг судлан тогтоосны үндсэн дээр нөхөн сэргээх арга технологийг ялгавартайгаар тогтоон, хэрэгжүүлэх менежментийг боловсронгуй болгох	2010-2015	БОАЖЯ, ЗТБХБЯ	ШУА
5.1.9	Усны нөөц болон байгалийн бусад нөөцийг зохистой ашиглах, хамгаалах цогц үйл ажиллагаатай уялдуулан менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх	2010-2015	БОАЖЯ, ЦТҮХ	Усны газар, ШУА, төсөл, хөтөлбөрүүд
5.1.10	Орд газруудыг ашиглах болон томоохон барилга байууламжуудыг барих үед илрэх газар доорхи усны экологийн болон бусад зориулалтаар бүрэн ашиглах	2010-2015	БОАЖЯ, ЗБЭХЯ	Усны газар, ШУА
5.1.11	Цөлжилт хүчтэй илэрсэн сумдыг сонгож, цөлжилттэй тэмцэх загвар сум бий болгон олон нийтэд сурталчлан таниулах	2010-2016	БОАЖЯ, ЗТБХБЯ	Бүх шатны Засаг дарга, ШУА, төсөл, хөтөлбөрүүд
5.1.12	Зарим хот, суурин газруудыг элсний нүүдлээс хамгаалах, ногоон бус байгуулах зэрэг технологийн шийдлийг олж тогтоох зорилгоор олон улсын туршлагыг судлан нэвтрүүлэх	2010-2015	БОАЖЯ, ЦТҮХ	Бүх шатны Засаг дарга, ШУА, төсөл, хөтөлбөрүүд

5.1.13	Зам, тээвэр зэрэг дэд бүтэц, аж үйлдвэрийн салбарт байгальд ээлтэй арга технологи, тоног төхөөрөмж ашиглаж буй аж ахуйн нэгжүүдийг урамшуулах, дэмжих	2010-2015	БОАЖЯ, ЗТБХБЯ, ЗБЭХЯ	Хувийн хэвшлийн байгууллага
5.1.14	Говь, хээрийн болон цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд унаган ургамлыг тарималжуулах, хур тундас нэмэгдүүлэх, ус хуримтлуулах, хиймэл нуур, хөв, цөөрөм байгуулах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хангах ажлыг дэмжих	2010-2015	БОАЖЯ	Бүх шатны Засаг дарга, ШУА, ТББ, хувийн хэвшил
5.1.15	Гол мөрний эх, сав газрыг хамгаалах, булаг шандны эхийг тохижуулах ажлыг эрчимжүүлэх	2010-2015	БОАЖЯ	Бүх шатны Засаг дарга, ШУА, ТББ, хувийн хэвшил
5.1.16	Цөлжилтөд нэрвэгдсэн бус нутагт мод уржүүлгийн газар байгуулах, мод сөөг тарих, ургамалжуулах үүсгэл санаачилгыг урамшуулан дэмжих	2010-2015	БОАЖЯ	ЦТҮХ, БХЯ, ШУА, Ой ашиглагчдын бүлгүүд, ТББ
5.1.17	Мод, сөөг тарих, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх зэрэг ажилд батлан хамгаалах салбарын цэргийн дүйцүүлэх болон жинхэнэ албаны бие бүрэлдэхүүний оролцоог нэмэгдүүлэх	2010-2015	БХЯ	БХЯ, ой ашиглагчдын бүлгүүд, ТББ
5.1.18	Заган ойг үрээр тарих, нөхөн сэргээх ажилд дэмжлэг үзүүлэх	2010-2015	БОАЖЯ	ЦТҮХ, ШУА, ОГ, ТББ, заг бүхий аймаг, сумдын Засаг дарга

5.1.19	Говь, цөлийн бүсэд байгалийн баянбүрдийг хамгаалах, сэргээх ажлыг төлөвлөгөөний үндсэн дээр зохион байгуулах;	2010-2015	БОАЖЯ	ШУА, төсөл, хөтөлбөрүүд, аж ахуйн нэгж, байгууллагууд
5.1.20	Эрчим хүчний бусад эх үүсвэрүүд (ахуйн хэрэглээний хийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, сум, суурин газрыг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох зэрэг)-ийг бий болгосноор гандуу бүс нутгийн мод, бут сеог, ургамлыг түлшний зориулалтаар ашиглаж байгааг хязгаарлах	2010-2015	ЗБЭХЯ	ШУА, аж ахуйн нэгж, байгууллагууд
5.1.21	Ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх тогтвортой менежментийг бий болгож, мод орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, модны хэрэглээг импортоор хангах санваачиглыг дэмжих замаар ой модны хэрэглээг багасгах	2010-2015	БОАЖЯ, ХХААХҮЯ	ШУА, ТББ, хувийн хэвшлийн байгууллагууд
5.1.22	Заг, харгана, шаваг зэрэг мод, бут сеогийг орлох шинэ төрлийн түлш, эрчим хүчний эх үүсвэр ашиглаж байгаа байгаль ашиглагчдын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжих	2010-2015	БОАЖЯ, ЗБЭХЯ	Ой ашиглагчдын бүлгүүд, ТББ
5.2. Байгалийн нөөц ашиглагчдын бүлгүүд, байгаль хамгаалагчдын нөхөрлөлүүдэд байгалийн нөөцийг зохиистой ашиглах эрх, үүргийн тогтолцоог бий болгох замаар байгалийн нөөцийн менежментийн төлөвлөгөө (бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, усны менежментийн төлөвлөгөө, ойн менежментийн төлөвлөгөө зэрэг)-г хэрэгжүүлнэ				
5.2.1	Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглагчдын эрх үүргийг тодорхой тусгаж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	2010-2015	ХХААХҮЯ	Бүх шатны Засаг дарга, ТББ, төсөл, хөтөлбөрүүд

5.2.2	Бэлчээр ашиглагч, малчдын бүлгийг нэгдсэн бүртгэлд хамруулж, тэдэнд арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	2010-2015	ХХААХУЯ	Бүх шатны Засаг дарга, ТББ, төсөл, хөтөлбөрүүд
5.2.3	Бэлчээрийг хамгаалах, хортон мэрэгчтэй тэмцэх, нөхөн сэргээх зэрэг ажлыг бэлчээр ашиглагч, малчдын бүлгүүд гүйцэтгэдэг механизмыг бүрдүүлэх	2010-2015	ХХААХУЯ	Бүх шатны Засаг дарга, ТББ, малчдын бүлгүүд
5.2.4	Нөхөрлөл, бүлгүүдийн үйл ажиллагааг доройтол илэрсэн болон эрсдэл өндөртэй газар нутгийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглүүлж, дэмжих	2010-2015	БОАЖЯ, ХХААХУЯ, ЭБЭХЯ	Ойн газар, Усны газар, ТББ, нөхөрлөл, бүлгүүд
5.2.5	Говь, хээрийн бүсийн бэлчээрийг усжуулах зорилгоор нар, салхины эрчим хүчээр ажилладаг худаг байгуулах	2010-2015	ХХААХУЯ, ЭБЭХЯ	Бүх шатны Засаг дарга, төсөл, хөтөлбөрүүд
5.2.6	Малын чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх, бүс нутгийн онцлог, бэлчээрийн даац багтаамжид тохируулан сүргийн оновчтой бүтцийг бий болгох, бодлогыг хэрэгжүүлэх, малчид болон малчдын бүлгүүдэд энэ талаархи мэдлэгийг бий болгох	2010-2015	ХХААХУЯ ШУА	
5.2.7	Сав газрын нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх зорилгоор сав газрын зөвлөлүүдийг байгуулж үйл ажиллагааг нь тогтмолжуулах	2010-2015	БОАЖЯ	ЦПУХ, Усны үндэсний хороо, Усны газар, Сав газрын зөвлөл
5.2.8	Гол мөрний урсацад тохируулга хийх, хуримтлагдсан усны нөөцийг гандуу, хуурай бүс нутагт шилжүүлэн ашиглах дэд бүтцийг бий болгох	2010-2015	БОАЖЯ	Усны үндэсний хороо, Усны газар, Сав газрын зөвлөл





5.2.9	Малчид, малтай байсан иргэдэд орлогын нэмэлт эх үүсвэр бий болгож байгальд үзүүлэх дарамтыг багасгах	2010-2016	НХХЯ, ХХААХҮЯ	Төсөл, хөтөлбөрүүд, ТББ
5.3	Үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжлийн нөлөөгөөр доройтолд орсон газар нутгийг нөхөн сэргээхэд байгалийн нөөц, баялаг ашиглаж байгаа иргэдийн оролцоог нэмэгдүүлж "нөөц ашиглагч төлөх" зарчмыг нэвтрүүлнэ			
5.3.1	Уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгчдийн байгаль орчинд ээлтэй арга, технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжих	2010-2015	ЗБЭХЯ	ШУА, төсөл, хөтөлбөрүүд
5.3.2	Уул уурхайн зориулалтаар ашигласан газар нутгийг нөхөн сэргээх журамд "нөөц ашиглагч төлөх" зарчмыг тусгаж, байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах механизмзыг бий болгох	2010-2015	БОАХЯ, ЗБЭХЯ	Хувийн хэвшлийн байгууллага, иргэд
5.3.3	Авто болон төмөр замын сүлжээг сайжруулах, цөлжилт, хуурайшилттай нутгийн замуудын орчинд элсний нүүлт, хөрсний элэгдэл, эвдрэл бий болохоос сэргийлсэн арга барил, технологийг туршиж, хэрэгжүүлэх	2010-2015	ЗТБХБЯ	ТЗГ, АЗГ, ШУА, төсөл, хувийн хэвшлийн байгууллага
5.3.4	Авто зам барих томоохон төсөл, хөтөлбөрүүдийг дэмжсэн бодлого хэрэгжүүлэх	2010-2016	ЗТБХБЯ, СЯ	АЗГ, төсөл, хөтөлбөрүүд, хувийн хэвшлийн байгууллага

5.4. Цөлжилтөд өртсөн бус нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг бусад хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй нягт уялдуулан, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, амьдрах орчныг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг нэмэгдүүлэх.				
5.4.1	Биологийн төрөл зүйлийг хамгаалах үндэсний хөтөлбөртэй харилцан уялдуулан биологийн төрөл зүйлийн хомсдол, цөлжилтөд хүргэж байгаа нөхцөлийг бууруулах арга хэмжээг цөлжилтөд өртөж байгаа газар нутагт зохион байгуулах	2010-2015	БОАЖЯ	ТХГН-ийн хамгаалалтын захиргаад, ШУА, төсөл, хөтөлбөрүүд, ТББ
5.4.2	Биологийн төрөл зүйлүүдийг хамгаалах ажилд төрийн ба төрийн бус байгууллага, орон нутаг, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	2010-2015	БОАЖЯ	Бүх шатны Засаг дарга, ТББ
5.4.3	Уур амьсгалын өөрчлөлтийн хандлагыг 5-10 жилээр нарийвчлан үнэлэх чадавхийг бий болгох, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагад нийцүүлэн чийг бага шаарддаг, ганд тэсвэртэй таримал ургамал сортыг судалж хэрэглэх, энэ чиглэлийн мод, модлог ургамлын шинэ төрөл зүйлийг туршин нутагшуулах	2010-2015	БОАЖЯ, ХХААХҮЯ	ШУА, судалгааны төлөв, төсөл, хөтөлбөрүүд, хувийн хэвшлийн байгууллага
5.4.4	Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөртэй уялдуулан цөлжилт, түүнээс үүдэлтэй байгалийн гамшгийн нөгөө болон эрсдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	2010-2015	БОАЖЯ	ЦУОШГ, ОБЕГ
5.4.5	Цэвэр хөгжлийн механизм, Даян дэлхийн байгаль хамгаалах сан зэрэг олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, хамтарсан төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ авах	2010-2015	БОАЖЯ	ШУА, төсөл, хөтөлбөрүүд

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2010 оны 05 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 15

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 26 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Захиргааны журмын эсрэг гэмт хэргийн талаар заасан Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс **ТОГТООХ НЬ:**

1. Эрүүгийн хуулийн /цаашид хуулийн гэх/ 230 дугаар зүйлийн 230.1-д заасан **"олон нийтийн байцаагч"** гэж тухайн нутаг дэвсгэрт нийгмийн хэв журам сахиулахаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу томилогдсон иргэнийг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан **"хууль бус үйлдэл хийлгэхээр албадсан"** гэдэгт хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн дагуу олгогдсон бүрэн эрх, үндсэн чиг үүрэгт нь илтэд харш үйлдэл гүйцэтгүүлэхээр тулган шаардахыг ойлгоно.

2. Хуулийн 231 дүгээр зүйлийн 231.1-д заасан **"олны өмнө"** гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 40 дүгээр тогтоолын 1.4-т заасантай адилтган ойлгож хэрэглэнэ.

3. Хуулийн 232 дугаар зүйлийн 232.2-т заасан **"олон нийтийн сонгуультай"** гэж нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дураараа эвлэлдэн нэгдсэн, төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллагаас сонгуулиар үүрэг хүлээсэн иргэнийг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан **"иргэний журамт үүрэг"**-т Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон үүргүүдийг хамааруулан үзэхээс гадна, хүний төрөлх чанарээс үлэнхитсэн ёс суртахууны зам замхсаагаар тодорхойлогддог зан үйлийн шаардлагыг ойлгоно.

4. Хуулийн 233 дугаар зүйлийн 233.1-д заасан **"хувийн бусад баримт бичиг"**, 234 дүгээр зүйлийн 234.1-д заасан **"хувийн бусад чухал баримт бичиг"** гэдэгт хүний хувийн байдлыг тодруулсан, гэрчилсэн, эдийн болон эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон, бүхий л төрлийн төлбөр, тооцоо хийснийг баталсан зэрэг



зориулалт нь тухайн хүний эрх, үүрэгтэй салшгүй холбоотой албан ёсны эсхүл эх бичвэр баримтыг хамааруулан үзнэ.

5. Хуулийн 234 дүгээр зүйлийн 234.1, 234.2-т тус тус заасан **"хувийн бусад сэдэлт"** гэдэгт энэ зүйл, хэсгүүдэд тодорхойлсон өс хонзонгийн болон шунахайн сэдэлтээс гадна бусдын захиалгаар, өөр гэмт хэргийг нуун далдлах буюу хялбарчлах зорилгоор, хэн нэгэнд туслахаар эсхүл атаархсан, албан тушаал дэвшихийг санаархсан гэх мэт ойлголтууд хамаарна.

6. Хуулийн 235 дугаар зүйлийн 235.1-д заасан **"төрийн архивын сан хөмрөг"**-т Архивын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан баримтууд хамаарна.

7. Хуулийн 236 дугаар зүйлийн 236.1-д заасан дураараа аашлах гэмт хэргийг хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн тохиолдолд үүний улмаас учирсан хор уршгийг харгалзан Эрүүгийн хуулийн аль тохирох зүйлээр давхар зүйлчилнэ.

8. Хуулийн 237 дугаар зүйлийн 237.1-д заасан **"цэргийн жинхэнэ албаны ээлжит татлагаас зайлсхийсэн"**, мөн зүйлийн 237.2-т заасан **"дайчилгаагаар татагдахаас зайлсхийсэн"** гэдэгт Монгол Улсын Иргэний Цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3, 30 дугаар зүйлийн 1-д тус тус заасны дагуу эрх бүхий албан тушаалтнаас товлон зарласан хугацаанд цэрэг татлагын байранд мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т заасан хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүйг ойлгоно.

9. Хуулийн 238 дугаар зүйлийн 238.1-д заасан **"албан журмын бусад үүрэг"**-т Дайны байдлын тухай хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан үүргийг тус тус хамааруулан үзнэ.

10. Хуулийн 240 дүгээр зүйлийн 240.1-д заасан **"эрхийн баримт бичиггүй"** гэж Монгол Улсад хүчин төгөлдөр бус болсон хуурамч баримт бичигтэй, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан хүчин төгөлдөр гадаад паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичиггүй, түүнчлэн дээрх баримт бичигтэй боловч Монгол Улсын эрх бүхий байгууллагаас оршин суух зөвшөөрөл аваагүй эсхүл мөн хуулийн 28 дугаар зүйлийн 1-д заасан **"Монгол Улсад оршин суух үнэмлэх"**-гүй байх зэргийг хэлнэ.

Мөн зүйл, хэсэгт заасан **"хүчингүй баримт бичиг"** гэдэгт Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгосон буюу буцаан авсан, гадаад паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн хугацаа дууссан, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан визний хугацаа хэтэрсэн, мөн хуулийн 25 дугаар зүйлийн 1-д заасан байнга оршин суух, цагаачлах зөвшөөрлийн хугацаа дуусгавар



болсон зэргийг хамааруулан үзнэ.

11. Хуулийн 241 дүгээр зүйлийн 241.1-д заасан “хууль бусаар ашигласан” гэдгийг Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11.12 дугаар зүйлийг зөрчсөнөөс гадна мөн хуулийн 14,15 дугаар зүйлд зааснаас бусад зориулалтаар “Улаан загалмай” нэр, бэлгэ тэмдгийг хэрэглэснийг ойлгоно.

12. Хуулийн 242 дугаар зүйлийн 242.1-д заасан “хүнд хор уршиг”-т хүний амь нас хохирсон, бие махбодид нь хүнд гэмтэл учирсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, хэд хэдэн хүний бие махбодид хүндэвтэр гэмтэл болон бусдын эд хөрөнгөд онц их хэмжээний хохирол учирсан зэргийг хамааруулж үзнэ.

13. Хуулийн 243 дугаар зүйлийн 243.1-д заасан “хуулиар хориглосон мөрийтэй тоглоом (казино)” гэдэгт ашиг хонжоо олох зорилгоор мөнгө буюу түүнийг орлогч металл (токенс) хэрэглэн тоглодог электрон хэрэгсэл, слот машин, мөн тоглоомын үйл ажиллагаанд мөнгийг орлуулан хэрэглэх зориулалтын тусгай хуванцар зоос (чип) буюу шоо, хөзөр, тэдгээрт зориулсан тоглоомын тусгай ширээ зэрэг казиногийн зориулалтаар өрөө, тасалгаа, тоног, төхөөрөмжийг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог бүхий л тоглоом хамаарна.

14. Хуулийн 244 дүгээр зүйлийн 244.1-д заасан “зохих зөвшөөрөлгүйгээр” гэдгийг төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан бичгийн хэлбэртэй, албан ёсны шийдвэргүйгээр гэж ойлгоно.

Бусдын эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйлсийг битүүмжлэх эрх төрийн байгууллага, түүний албан тушаалтанд зөвхөн хуулиар олгогдсон байх ёстойг анхаарвал зохино.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**

**С.БАТДЭЛГЭР**

**ЗРҮҮГИЙН ХЭРГИЙН  
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.БАТСАЙХАН**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн редакци

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [tamin\\_medeel@parliament.mn](mailto:tamin_medeel@parliament.mn)

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 4

Надекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.  
Үгэс 329487